



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ
БАЙРЛАХ “ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН БАЯНХӨНДИЙ
АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

Contents	
ОРШИЛ	5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ.....	6
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	10
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	10
Төслийн нэр:.....	10
“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төсөл.....	10
Төсөл хэрэгжүүлэгч:.....	10
1.2. Төслийн зорилго.....	14
1.3. Төслийн хүчин чадал, хэрэгжих хугацаа.....	14
1.4. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт.....	15
1.5. Төслийн одоогийн байдал	16
1.6. Хашаажуулалт	17
1.7. Уурхайн ажлын горим	17
1.8. Уурхайн ажилчдын хотхон.....	17
1.9. Хүдэр боловсруулах үйлдвэр.....	18
1.9.1. Үйлдвэрийн одоогийн байдал	20
1.9.2. Үйлдвэрийн технологийн горим	21
1.9.3. Лаборатори	25
1.9.4. Химийн бодис	25
1.9.5. Урвалж бодисын агуулах.....	27
1.9.6. Хаягдлын нэгдсэн сан.....	27
1.10. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг ашиглах шороон орд.....	27
1.11. Уурхайн нээлт	30
1.11.1. Тэсэлгээний ажил	31
1.11.2. Агуулах	32
1.12. Хүнд хөнгөн машин механизмын засвар	34
1.13. Шатахуун түгээх станц	35
1.14. Цахилгаан хангамж	36
1.14.1. Төслийн цахилгаан хангамж.....	38
1.15. Бохир ус цэвэрлэх байгууламж	38
1.16. Уурхайн дулаан хангамж.....	39
1.16.1. Уурын зуухны буюу бойлерын байгууламж	40
1.17. Усан хангамж	40

1.17.1. Ус хангамжийн эх үүсвэр	41
1.17.2. Уурхайн кемпийн унд, ахуйн усны хэрэгцээ	42
1.17.3. Замын тоос дарах усалгаа	42
1.17.4. Боловсруулах үйлдвэрийн усны хэрэглээ.....	43
1.17.5. Биологийн нөхөн сэргээлт	43
1.18. Тээвэрлэлт	43
1.18.1. Хүн тээвэр	43
1.18.2. Хүнс тээвэр.....	43
1.18.3. Ачаа тээвэр.....	44
1.18.4. Дотоод зам.....	45
1.18.5. Агаарын харилцаа.....	46
1.19. Холбоо харилцаа.....	47
1.20. Хүний нөөцийн бодлого	47
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	49
2.1. Физик газарзүй.....	49
2.2. Уур амьсгал	49
2.3. Гадаргын ус	49
2.4. Газрын доорх ус	49
2.5. Хөрсөн бүрхэвч	50
2.6. Ургамлан нөмрөг	50
2.7. Амьтны аймаг	50
2.8. Нийгэм - Эдийн засаг.....	51
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ҮНДСЭН БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	52
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	55
4.1. Зорилго, зорилт	55
4.1.1. Баримтлах зарчим	55
4.1.2. Хамрах хүрээ.....	55
4.1.3. Төслийн барилга байгууламж.....	56
4.1.4. Ил уурхайн хэсэг	56
4.1.5. Боловсруулах үйлдвэрийн хэсэг.....	56
4.1.6. Ажилчдын кемп	57
4.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй.....	60

4.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	61
Модны усалгааг дэмжих хувин турших	69
4.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	74
4.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	79
4.5.1. Дүйцүүлэн хамгааллын талаар баримтлах бодлого	79
4.5.2. Нөлөөлөлд өртөх болон дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ	81
4.5.3. Дүйцүүлэн хамгаалах газрын санал болгож байгаа байршлууд.....	81
4.6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	82
4.7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	82
4.8. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	83
4.9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	84
4.10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	88
4.11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	93
4.12. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	98
4.13. БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	98
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	100
Хавсралтын жагсаалт	101
<i>Хавсралт 2</i>	104

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Дагаж мөрдөх хууль	6
Хүснэгт 2. Дагаж мөрдөх стандартууд	7
Хүснэгт 3. Дагаж мөрдөх Байгаль орчны дүрэм, журам	8
Хүснэгт 4. Хөндий (MV-021444) тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбицол.....	11
Хүснэгт 5. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд	15
Хүснэгт 6. Гүний худгуудын мэдээлэл	41
Хүснэгт 7. Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	52
Хүснэгт 8. 2024 онд баригдсан барилгын ажлын гүйцэтгэл, 2025 онд барихаар төлөвлөсөн барилгын ажил.....	57
Хүснэгт 9. БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2025 он.....	61
Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	62
Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	77
Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	80

Хүснэгт 13. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	82
Хүснэгт 14. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	83
Хүснэгт 15. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	84
Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	86
Хүснэгт 17. Хог хаягдлын ангилал, тэдгээрийг устгах аргууд	88
Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	90
Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	94
Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	98
Хүснэгт 21. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	99

ЗУРАГ

Зураг 1. Баянхөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг.....	11
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт	16
Зураг 3. Төслийн талбайн хашаажуулалт	17
Зураг 4. Уурхайн хотхоны ерөнхий байдал.....	18
Зураг 5. Боловсруулах үйлдвэрийн план зураг	19
Зураг 6. Хүдэр боловсруулах үйлдвэрийн технологийн ерөнхий схем.....	20
Зураг 7. Үйлдвэрийн барилгийн ажлын явц	21
Зураг 8. Хөндий төслийн талбайд байрлах түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газруудын байршил	28
Зураг 9. Тойгийн дайрганы ил уурхайн 3 хэмжээст загварчлал.....	29
Зураг 10. Төвийн дайрганы ил уурхайн 3 хэмжээст загварчлал	29
Зураг 11. Ангийн шаврын ил уурхайн 3 хэмжээст загварчлал.....	30
Зураг 12. Ил уурхайн ажлын хамгийн бага талбай бэлтгэх схем.....	31
Зураг 13. Ил уурхайн ашиглалтын 1-р жилийн дэвсгэр зураг.....	31
Зураг 14. Бараа, материалын агуулахын төлөвлөлт.....	32
Зураг 15. Агуулахын талбайн ерөнхий төлөвлөгөө.....	34
Зураг 16. Хүнд, хөнгөн машин механизмын засварын газрын 3D план.....	35
Зураг 17. Шатахуун түгээх станцын зохион байгуулалт.....	36
Зураг 18. Баянхөндий-Нарийнсухайт 110 кВ-ын ЦДАШ-ын трасс	37
Зураг 19. Баянхөндий-Нарийнсухайт 110 кВ-ын ЦДАШ	37
Зураг 20. Бохир ус цэвэрлэх байгууламж	39
Зураг 21. Уурын зуухын зохион байгуулалт	40
Зураг 22. Ус хангамжийн системийн схем.....	42
Зураг 23. “Замын чиглэл тогтоох тухай” захирамж.....	45
Зураг 24. Төслийн дотоод замын трасс болон хөндлөн огтлол.....	46
Зураг 25. Эрдэнэ Монгол ХХК, байгууллагын бүтэц, зохион байгуулалт 2025	48
Зураг 26. Нөхөн сэргээлт хийсэн газрын байршил, 2022 он	82

ОРШИЛ

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутагт “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. “Эрдэнэ Монгол” ХХК нь Байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн туршлага, менежментийг нэвтрүүлж олон нийтэд нээлттэй, хариуцлагатай уул уурхайн жишиг төсөл болох зорилго тавин ажиллаж байна.

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заасны дагуу хийж гүйцэтгэв.

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээр сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ зэргийг боловсруулан БОАЖЯ-аар 2021 онд батлуулсан, 2024 оны БОМТ боловсруулж батлуулан, биелэлтийн тайланг Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны А/22 дугаар захирамжаар байгуулагдсан БОМТ-ний биелэлтийг шалгах ажлын хэсгийн гишүүдээр 2024 оны 10 дүгээр сарын 28-оос 30-ны өдрүүдэд 90.05 хувиар дүгнүүлсэн.

Тус компанийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар 2025 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан, холбогдох зардлуудыг тусгав.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

Энэ бүлэгт уг төслийг хэрэгжүүлэх явцад мөрдвөл зохих үндэсний болон Олон улсын бодлого, холбогдох хууль журмыг нэгтгэн оруулсан.

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК нь эдгээр бодлого, холбогдох хууль журмыг сахин биелүүлж төслөөс учрах аливаа сөрөг нөлөөллийг Монгол Улсын холбогдох хууль, журам дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хамгийн бага түвшинд, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах үүрэг хүлээж байгаа (**Error! Reference source not found.**-д харуулав).

Хүснэгт 1. Дагаж мөрдөх хууль

Д/д	Байгаль орчинтой холбоотой хууль, журмууд	Анх батлагдсан огноо	Шинэчлэн батлагдсан огноо
1.	Агаарын тухай хууль	2006.07.08	2023.01.06
2.	Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хууль	2010.06.24	2019.11.13
3.	Ашигт малтмалын тухай хууль	2006.07.08	2023.01.06
4.	Амьтны тухай хууль	2000.05.05	2023.01.06
5.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995.03.30	2023.01.06
6.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	2012.05.17	2023.01.06
7.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2012.05.17	2023.01.01
8.	Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, аюулгүй болгох, хадгалах, устгах журам	2018.05.02	2018.05.02
9.	Газрын тухай хууль	2002.06.07	2023.01.06
10.	Гамшгаас хамгаалах тухай	2017.02.02	2023.01.06
11.	Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газарт ашигт малтмал олборлох, хайхыг хориглох тухай хууль	2009.07.16	2015.12.04
12.	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам	2003.02.07	2003.02.07
13.	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам		2017.05.23
14.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	2012.05.17	2023.01.01
15.	Хог хаягдлын тухай	2017.05.12	2023.01.01
16.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	1994.11.15	2023.01.06
17.	Усны тухай хууль	2004.04.22	2023.01.06
18.	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам		2013.05.16
19.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	2012.05.17	2022.06.03
20.	Соёлын тухай хууль	1988.11.19	2023.01.06
21.	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	2001.06.08	2023.01.06
22.	Уурхай, нөөцийн болон Боловсруулахүйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам батлах тухай (А/181, А/458)	2017.03.16	2019.08.28
23.	БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам (А/618)	2019.10.29	2019.10.29

Хүснэгт 2. Дагаж мөрдөх стандартууд

Д/д	Стандартын тэмдэглэгээ	Стандартын нэр
Хөрс, ургамал		
1.	MNS 3985:1987	Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл.
2.	MNS 5850:2019	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.	MNS 3475:2003	Ургамлын хорио цээр. Нэр томьёо, тодорхойлолт.
4.	MNS 3298:1991	Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага.
Ус		
5.	MNSISO24511:2012	Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ. Ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшнийг үнэлэх аргачлал. үнэлэх заавар
6.	MNS 4943:2015	Усны чанар, Хаягдал бохир ус
7.	MNS 4586:1998	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.
8.	MNS 3597:1983	БО-ны хамгаалал, Усан мандал. Гадаргын ба газрын доорх усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага
9.	MNS 3342:1982	БО-ны хамгаалал, Усан мандал. Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
10.	MNS 6148:2010	Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
11.	MNS 0900:2018	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
12.	MNS 3935:1986	Ахуйн хэрэгцээ, ундны зориулалттай ус. Хээрийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага.
Агаарын чанар		
13.	MNS 4585:2016	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
14.	MNS 5885:2008	Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.
15.	MNS 3383:1982	Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо, тодорхойлолт.
Нөхөн сэргээлт		
16.	MNS 5914:2008	БО. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
17.	MNS 5915:2008	БО. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал.
18.	MNS 5916:2008	БО. Үржил шимт хөрсийг хуулах шаардлага.
19.	MNS 5917:2008	БО. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
20.	MNS 5918:2023	БО. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
21.	MNS 4943:2018	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага

Хүснэгт 3. Дагаж мөрдөх Байгаль орчны дүрэм, журам

#	Журам	Тайлбар
1.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам. <i>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалын хавсралтаар батлагдсан.</i>	Мөн энэхүү журамд олон нийтийн оролцоог хангах шаардлагыг стратегийн, хуримтлагдах нөлөөллийн, ерөнхий ба нарийвчилсан үнэлгээ гэсэн үнэлгээний төрөл тус бүрээр зааж өгсөн байна. Эдгээрээс хамгийн чухал заалтуудын нэг нь 2.7-д заасан “Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна” юм.
2.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам. <i>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралтаар баталсан.</i>	Төсөл хэрэгжүүлэгч нь тус журмын 1.6-р зүйлд зааснаар журмын 1.5-т заасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана.
3.	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам. <i>Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан.</i>	Монгол Улсын иргэнд өмчлүүлэх болон иргэний өмчийн газар, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон тэдний эзэмшиж, ашиглаж байгаа газар, гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль тогтоомжийн дагуу ашиглуулах болон ашиглуулж байгаа газарт, түүнчлэн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоогүй төрийн өмчийн бусад газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийхэд энэхүү журмыг баримтална. Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт төлөвлөгөөт хянан баталгааг 5 жилд нэг удаа хийнэ. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар газар олгох, Газрын тухай хуулийн 16.1.3-16.1.8-д зааснаар газрыг тусгай хэрэгцээнд авах болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход тухай бүр хянан баталгааг хийнэ.
4.	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам. <i>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 тоот тушаалын хавсралтаар батлагдсан.</i>	Энэхүү журмыг ус олборлох, дамжуулах, нөөцлөх, борлуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа ус хангагч, усны тоолуурын хэмжил зүйн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болон ус ашиглагч, хэрэглэгч дагаж мөрдөнө. Унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын усны олборлолт, дамжуулалт, нөөцлөлт, борлуулалт, хаягдал усны тоо хэмжээг тогтоох ба ашиглалтын тайлан мэдээг гаргах ажилд эрх бүхий

		байгууллагаар баталгаажуулсан усны тоолуурын заалтыг үндэслэнэ.
5.	Байгаль орчинд халгүй, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуй нэгж байгууллагыг урамшуулах журам. <i>Байгаль орчныг хамгаалах тухай хууль</i> ”-ийн 19 дүгээр зүйлийн 5 дугаар заалтын дагуу Засгийн газрын 1998 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан ба Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.	Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөлөл, бохирдлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, байгаль орчинд халгүй, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи /цаашид "халгүй технологи" гэнэ/ нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулахад энэ журмыг дагаж мөрдөнө. Байгаль орчинд халгүй технологи гэдэгт хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд сөрөг үр дагавар учруулахгүй, орчиндоо хоргүй, бохирдол багатай, хаягдалгүй байх чадвартай үйлдвэрлэл, үйлчилгээний бүхий л төрөл, хэлбэр хамаарна.
6.	Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам. <i>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/428 тушаалын хавсралт</i>	Хог хаягдлын тоо бүртгэлийг хөтөлж, нэгтгэн боловсруулах, тайлагнах, албан ёсны статистик мэдээллийг бүрдүүлэхтэй холбогдсон төрийн захиргаа, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хоорондын харилцааг зохицуулдаг журам бөгөөд энэхүү журмын дагуу батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын хор аюулын зэрэглэлээр кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, энэ журмаар тогтоосон хугацаанд тайлангаа сум дүүргийн Засаг дарга эсхүл түүний томилсон этгээдэд гаргаж өгнө.
7.	Аюултай хаягдлын хадгалалт, устгалын бүртгэл хөтөлж, мэдээ гаргах заавар <i>Байгаль орчны сайдын 2003 оны 127 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт батлагдсан.</i>	Аюултай хаягдал гаргагч иргэн, Аж ахуйн нэгж, байгууллага нь аюултай хаягдлын хадгалалт, устгалын тайланг сум, дүүргийн Засаг даргад жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлнэ.
8.	Агаарын чанарын мэдээлэл гаргах журам <i>БОАЖЯ сайдын 2018 оны А/222 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан.</i>	Агаарын тухай хуулийн 9.1.4-д зааснаар аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах үүрэгтэй. Түүнээс гадна аж ахуйн нэгж байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх ёстой (Агаарын тухай хуулийн 9.1.5).
9.	Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтын журам. Энэ журмыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан.	3.7.11-р дугаар заалтад дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх шаардлагатай хэмээн тусгасан байдаг. Түүнчлэн 4.1.2-д аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хяналт шалгалт хийхээр заажээ.

10.	<p>Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам</p> <p><i>Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаалын хавсралт</i></p>	<p>Тус журмын 2.2-т Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь үүсгэж буй барилгын хог хаягдлаа эх үүсвэр дээр нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх шинж чанараар тодорхойлж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дүгээр тушаалаар батлагдсан Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн “аюултай”, “хяналттай”, “энгийн” зэрэглэлд хамрагдсанаар нь ангилан ялгах аар заажээ.</p>
-----	--	---

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

"Эрдэнэ Монгол" ХХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсан ба тус компанийг Торонто, Монголын хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци" (тэмдэг: ERDN), Хонг Конгийн Хөрөнгийн Бирж (тэмдэг: 975) бүртгэлтэй “Монголиан Майнинг Корпорэйшн” ХХК-д хамтран MV-02144 дугаартай “Хөндий” тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)-тэй стратегийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээг 2023 оны 01-р сард байгуулж байсан юм. Улмаар 2024 оны 01 сарын 23-ны өдөр Баянхөндий төслийг хөгжүүлэхээр Монголиан Майнинг Корпорэйшн (ММС)-тэй байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээг эцэслэн Эрдэнэ Монгол компанийн 50%-ийг эзэмшдэг.

Төслийн нэр: “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: **Байгууллагын нэр:** Гадаадын хөрөнгө оруулалттай “Эрдэнэ Монгол” ХХК

Улсын бүртгэлийн дугар: 9019005124


Регистрийн дугаар: 2718243

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД 8-р хороо, Сентрал таур, 16 давхар

Утас: +976 77118534

Төслийн нэр, байршил:

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшдэг MV-02144 дугаартай “Хөндий” тусгай зөвшөөрлийн талбай нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутагт байрладаг. “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбай нь Улаанбаатар хотоос 980 км, Баянхонгор аймгийн төв Баянхонгор хотоос баруун урагш 340 км, Шинэжинст сумын төвөөс баруун урагш 100 орчим км зайтай.



Зураг 1. Баянхөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг

Ашигт малтмалын газрын ГУУКХ-ийн даргын шийдвэрээр “Эрдэнэ Монгол” ХХК-д Хөндий нэртэй газар хайгуулын XV-015569 тусгай зөвшөөрөлтэй 19936.34 га талбайг 2010 онд олгож, хайгуулын ажлын явцад “Эрдэнэ Монгол” ХХК-ийн хүсэлтээр 2014 онд 15422.01 га талбайг буцаан, 4514.33 га талбайд хайгуулын ажлыг үргэлжлүүлэн хийж, 2308.62 га талбайд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон ба үлдсэн 2205.71 га талбайг буцаан өгсөн.

Хөндий талбайд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнг 2019 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж нөөцийг батлуулсан бөгөөд “Эрдэнэ Монгол” ХХК-д АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр 2019 оны 08 дугаар сарын 05-нд ашигт малтмал ашиглах MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий 2308.62 га талбайг 30 жилийн хугацаатай олгосон.

Хүснэгт 4. Хөндий (MV-021444) тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбицол

Тусгай зөвшөөрөл	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
MV-021444 (2,308.62га)	2019-08-05	30	1	98 ⁰ 48' 40"	43 ⁰ 53' 50"
			2	98 ⁰ 47' 18.81"	43 ⁰ 53' 50"
			3	98 ⁰ 46' 33.93"	43 ⁰ 57' 36.11"
			4	98 ⁰ 50' 0.34"	43 ⁰ 57' 36.11"
			5	98 ⁰ 50' 0.34"	43 ⁰ 55' 30"
			6	98 ⁰ 48' 40"	43 ⁰ 55' 30"

Ордын нөөц: Баянхөндий алтны үндсэн ордод 2010-2018 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг (ордын нөөц 2018 оны 10 дугаар сарын 31-ны байдлаар) ЭБМЗ-ийн 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны ХХ-06-10 тоот дүгнэлтийг үндэслэн

АМГТГ-даргын 2019 оны 06-р сарын 10-ны өдрийн н/46 тоот тушаалаар алтны ордын геологийн нөөцийг 0.2 гр/тн захын агуулгаар бодитой (В) зэрэглэлээр 4,701,140 тн исэлдсэн хүдэрт 1.84 гр/тн дундаж агуулгатай 8,628.65 кг, 2,004,650 тн анхдагч хүдэрт 1.82 гр/тн дундаж агуулгатай 3,654.26 кг, нийт бодитой (В) зэрэглэлээр 12,282.9 кг, боломжтой (С) зэрэглэлээр 4,886,265 тн исэлдсэн хүдэрт 0.73 гр/тн дундаж агуулгатай 3,569.98 кг, 11,101,615 тн анхдагч хүдэрт 0.57 гр/тн дундаж агуулгатай 6,308.84 кг, нийт боломжтой (С) зэрэглэлээр 9,878.82 кг, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 22,161.72 кг алтны нөөцийг улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна. 2019-2023 онуудад гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын хүрээнд нийтдээ 353 цооног, 33,375.48 тууш метр өрөмдлөг хийж Баянхөндий алтны үндсэн ордын нөөцийн тодотгол, Хар морь алтны үндсэн ордын нөөцийн тооцооны тайланг (Ордын нөөц 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар) гүйцэтгэсэнээр ЭБМЗ-ийн 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны ХХ-10-13 тоот дүгнэлтийг үндэслэн ҮГА-даргын 2024 оны 08-р сарын 28-ны өдрийн н/55 тоот тушаалаар Баянхөндий алтны үндсэн ордын нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 10,553,023.04 тн хүдэрт 1.5 гр/тн дундаж агуулгатай 15,789.57 кг алт, 0.79 гр/тн дундаж агуулгатай 8,335.60 кг мөнгө, боломжтой (С) зэрэглэлээр 17,297,112.01 тн хүдэрт 0.64 гр/тн дундаж агуулгатай 11,035.31 кг алт, 0.56 гр/тн дундаж агуулгатай 9,728.25 кг мөнгө, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 27,850,135.06 тн хүдэрт 0.96 гр/тн дундаж агуулгатай 26,824.88 кг алт, 0.65 гр/тн дундаж агуулгатай 18,063.85 кг мөнгө, Хар морь алтны үндсэн ордын нөөцийг боломжтой (С) зэрэглэлээр 7,313,510.06 тн хүдэрт 0.67 гр/тн дундаж агуулгатай 4,903.03 кг алт, 0.68 гр/тн дундаж агуулгатай 4,967.07 кг мөнгөний нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан.

Ил уурхай: Ордын уул геологийн нөхцөл, хүдрийн биетийн хэлбэр ба байршил, хөрсний зузаан зэрэгт үндэслэн ил уурхайн аргаар, автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ (тодотгол)-ийг боловсруулав. Баянхөндий болон Хар морь алтны үндсэн ордын ил уурхайн хүрээ хязгаарыг NPV Scheduler аргачлалыг ашиглан тодорхойлсон бөгөөд оновчлолын үр дүнд:

- Баянхөндий ил уурхайн хүрээнд нийт 13.37 сая.тн хүдэрт 1.37 гр/тн алтны дундаж агуулгатай, 18.28 тн алт, 0.81 гр/тн мөнгөний дундаж агуулгатай, 10.82 тн мөнгө үүнээс эдийн засгийн үр ашигтай 5.10 сая.тн хүдэрт 3.27 гр/тн алтны дундаж агуулгатай, 16.67 тн алт, 1.60 гр/тн мөнгөний дундаж агуулгатай, 8.15 тн мөнгө, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай 8.27 сая.тн хүдэр өртөж байна. Ил уурхайн хүрээний гадна 17.84 сая.тн хүдэрт 0.54 гр/тн алтны дундаж агуулгатай, 9.55 тн алт, 0.45 гр/тн мөнгөний дундаж агуулгатай, 8.00 тн мөнгөний нөөц үлдэж байна.
- Хар морь ил уурхайн хүрээнд нийт 0.58 сая.тн хүдэрт 2.72 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.59 тн алт, 1.81 гр/тн мөнгөний дундаж агуулгатай, 1.06 тн мөнгө үүнээс эдийн засгийн үр ашигтай 0.25 сая.тн хүдэрт 5.94 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.50 тн алт, 2.54 гр/тн мөнгөний дундаж агуулгатай, 0.64 тн мөнгө, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай 0.33 сая.тн хүдэр өртөж байна. Ил уурхайн хүрээний гадна 6.73 сая.тн хүдэрт 0.49 гр/тн алтны дундаж агуулгатай, 3.32 тн алт, 0.58 гр/тн мөнгөний дундаж агуулгатай, 3.91 тн мөнгөний нөөц үлдэж байна.

Хүдрийн биетийн хэлбэр, уналын өнцөг, олборлолтын доголын өндрөөс хамааруулан ашиглалтын түвшин бүрд олборлолтын үеийн хаягдал болон бохирдлыг тооцоход ордын хэмжээнд олборлолтын үеийн бохирдол дунджаар 9%, олборлолтын үеийн хаягдал дунджаар 2% байх бөгөөд үйлдвэрлэлийн нөөцийн тооцооны үр дүнд:

- Баянхөндий ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц нийт бодитой болон боломжтой (B+C) нөөцийн зэрэглэлээр 14,281.14 мян.тн хүдэрт 1.25 гр/тн дундаж агуулгатай 17.91 тн алт, 0.74 гр/тн дундаж агуулгатай 10.60 тн мөнгө үүнээс 7,986.04 мян.тн исэлдсэн хүдэр, 1.57 гр/тн дундаж агуулгатай 12.55 тн алт, 0.89 гр/тн дундаж агуулгатай 7.11 тн мөнгө, 6,295.11 мян.тн анхдагч сульфидийн хүдэр, 0.85 гр/тн дундаж агуулгатай 5.37 тн алт, 0.55 гр/тн дундаж агуулгатай 3.49 тн мөнгө өртөж байна.
- Хар морь ил уурхайн хүрээнд нийт боломжтой (C) нөөцийн зэрэглэлээр 623.39 мян.тн хүдэр, 2.49 гр/тн дундаж агуулгатай 1.55 тн алт, 1.66 гр/тн дундаж агуулгатай 1.03 тн мөнгө үүнээс исэлдсэн хүдэр 386.96 мян.тн, 3.42 гр/тн дундаж агуулгатай 1.32 тн алт, 1.74 гр/тн дундаж агуулгатай 0.67 тн мөнгө, завсрын хүдэр 182.63 мян.тн, 1.10 гр/тн дундаж агуулгатай 0.20 тн алт, 1.46 гр/тн дундаж агуулгатай 0.27 тн мөнгө, анхдагч сульфидийн хүдэр 53.79 мян.тн хүдэр, 0.57 гр/тн дундаж агуулгатай 0.03 тн алт, 1.80 гр/тн дундаж агуулгатай 0.09 тн мөнгөний нөөц тус тус олборлолтод өртөж байна.

Ил уурхайн хүчин чадлыг боловсруулах үйлдвэрийн хүчин чадалаас хамааруулан хүдэр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал 650.0 мян.тн/жил байна. Ордыг ил аргаар ашиглах 7 жилийн хугацаанд нийт 28.17 сая.м³ уулын цул үүнээс 14.90 сая.тн хүдэр олборлож, 22.52 сая.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 1.51 м³/тн байхаар ТЭЗҮ-ний тодотголд оруулахаар тооцсон.

Барилгын материалын ордуудыг ашиглах ил уурхай: Ил уурхайн олборлолтын үеийн хаягдлын тооцоог хийхдээ ил уурхайн хүрээнд өртөж буй барилгын материалын ордуудын ил уурхайн нөхцөлд тулгуурлан хаягдлыг 10 см байхаар тооцоход олборлолтын үеийн хаягдал дунджаар 1.0% байхаар тооцсон ба бохирдлыг практик болон зөвшөөрөгдөх хэмжээнд буюу дунджаар 1.5% байхаар тооцон авсан болно. Тойг болон Төвийн дайргын ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц нийт 1,332.43 мян.м³, Ангийн шаврын ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц нийт 274.73 мян.м³ тус тус байхаар ТЭЗҮ-ний тодотголд оруулахаар тооцсон.

Хүдэр боловсруулах үйлдвэр: Баянхөндий болон Хар морь алтны үндсэн ордуудыг ил уурхайн аргаар боловсруулах үйлдвэрийг 10 жилийн хугацаанд жилд 650.0 тн хүдэр тэжээх төлөвлөгөөгөөр нийт 5.72 сая.тн хүдрээр хангана. Хүдэр тэжээлтийн төлөвлөгөөний алтны дундаж агуулга 3.11 г/тн, мөнгөний дундаж агуулга 1.51 г/т-тай хүдрийг уусган, дунджаар 92.72%-ийн алтны металл авалт, 55%-ийн мөнгөний металл авалттай нийт 16.478 тн алт, 4.737 тн мөнгө үйлдвэрлэхээр ТЭЗҮ-ийн тодотголд оруулахаар тооцсон

Усан хангамж: Төсөл хэрэгжүүлэгч нь гидрогеологийн хайгуул судалгааны ажлын хүрээнд 61.5-200 м гүнтэй 18 ширхэг цооногийг өрөмдсөн байна. Тус цооногуудын 8 ширхэг цооног нь үйлдвэрийг 2 үе шатаар усаар хангах бөгөөд тус худгууд нь нийт 17.4 л/сек ундаргатай. Хүдэр боловсруулах үйлдвэрт шаардлагатай усны ундарга хамгийн ихдээ 5.62 л/сек, технологийн ус ашиглалтын коэффициент 92%, төслийн нийт шаардлагатай усны ундарга 7.8 л/сек байна.

Цахилгаан хангамж: Баянхөндий алтны үндсэн ордыг Баруун бүсийн эрчим хүчний системээс хангах боломжгүй бөгөөд төслийн цахилгааны хэрэглээг найдвартай хангахын тулд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийн сухайт дэд станцаас 110 кВ-ын 242 км урттай ЦДАШ-аар цахилгаанаар хангахаар тооцсон. Тус цахилгаан хангамжийн эх үүсвэр нь 2025 оны 4-р сард ашиглалтад орох бөгөөд бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Төслийн нийт цахилгааны суурилагах чадал 9,930.54 кВт бөгөөд боловсруулах үйлдвэр 7,580.17 кВт, бусад цахилгаан хэрэглэгчид 2,350.4 кВт тус тус байхаар ТЭЗҮ-ийн тодотголд оруулахаар тооцсон.

Зах зээлийн судалгаа: Энэхүү төсөл нь дунд хугацаанд буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих төсөл учир зах зээлийн нөхцөл байдал, дунд хугацааны үнийн таамаглалыг үндэслэн 1 унци алтны үнийг 2,400.0 ам.доллар, 1 унци мөнгөний үнийг 30.0 ам.доллар байхаар тооцоолсон.

Эдийн засгийн үр өгөөж: Төслийн эдийн засгийн тооцооллыг ордын структур бүтэц, нөөцийн загвар, чанар, ордын уул техникийн нөхцөлд үндэслэн хийсэн ил уурхайн төлөвлөлт, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомж, заавар, журам, стандартад нийцүүлэн гүйцэтгэсэн. Төсөл хэрэгжих 10 жилийн хугацаанд нийт 470.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдах ба нийт 4,327.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 2,594.1 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажиллана. Татвар төлсний дараа 1,308.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 2.3 жил байна. Төсөл хэрэгжих 10 жилийн хугацаанд нийт 736.1 тэрбум төгрөгийг улс орон нутгийн төсөвт татвар, төлбөр хэлбэрээр төлнө. Хорогдуулалтын нормыг жилийн 10 хувиар тооцооход төслийн өнөөгийн үнэ цэнэ (NPV,_{@10%}) 600.1 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 41.1 хувь байгаа нь төсөл эдийн засгийн хувьд үр ашигтай болохыг харуулж байна.

1.2.Төслийн зорилго

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Баянхөндий алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах, боловсруулах үйлдвэр болон Барилгын материалын ордуудыг ил аргаар ашиглах төслийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагааг явуулж, эдийн засгийн хувьд үр ашигтайгаар, байгалийн баялгийг зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, мөн компанийн ажилтнууд болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

1.3.Төслийн хүчин чадал, хэрэгжих хугацаа

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт Хөндий нэртэй газар орших Баянхөндийн алтны үндсэн ордоос 5 жилийн хугацаанд гадаад овоолготой, ил аргаар алт олборлоно.

Ашиглалтын хугацаанд 40.05 сая тонн хөрс хуулалтын ажил хийж, хаягдал бохирдол тооцоогүй дүнгээр нийт 2.26 сая тонн исэлдсэн хүдэр, 0.51 сая тонн анхдагч хүдэр, 5.32 сая тонн ядуу хүдэр (ядуу хүдэр гэж өнөөгийн эдийн засгийн нөхцөлд үр ашиггүй нөөцийг нэрлэсэн) олборлоно. Боловсруулах үйлдвэр нь жилд 600 мян.тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд нийт 10.3 тн алт ялган авахаар 2019 оны ТЭЗҮ-д тусгасан. 2025 онд ТЭЗҮ-ний тодотголоор Ил уурхайн хүчин чадлыг боловсруулах үйлдвэрийн хүчин чадлаас

хамааруулан хүдэр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал 650.0 мян.тн/жил байна. Ордыг ил аргаар ашиглах 7 жилийн хугацаанд нийт 28.17 сая.м³ уулын цул үүнээс 14.90 сая.тн хүдэр олборлож, 22.52 сая.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 1.51 м³/тн байхаар төлөвлөж оруулахаар тооцож байна.

1.4.Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт

Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах хугацаанд ил уурхай, гадаад овоолгууд, Боловсруулахүйлдвэр, уурхайн ажилчдын хотхон болон засвар, үйлчилгээний барилга байгууламжууд баригдана. Эдгээр барилга байгууламжуудыг 117.44 га талбайд барихаар зураг төслийг боловсруулсан.

Төслийн бүтээн байгуулалт 2024 оны сүүлийн улирлын байдлаар 67%-тай байна. Төсөл хэрэгжих хугацаанд дараах объектууд нэгдсэн цогцолбор байдлаар баригдаж төслийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх юм. Үүнд:

Хүснэгт 5. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд

№	Барилга байгууламж	Талбай, га	Эзлэхүүн, мян.м ³
2.	Авто зам	20.48	
3.	Авто машины зогсоол	2.52	
4.	Боловсруулахүйлдвэр	2.94	
5.	Дулаан хангамжийн байгууламж	0.50	
6.	Засварын газар	0.22	
7.	Ил уурхай	30.16	
8.	Тэсрэх бодисын агуулах	0.13	
9.	Уурхайн ажилчдын хотхон	1.40	
10.	Уурхайн оффис	0.19	
11.	Халаалтын зуух	0.50	
12.	Хаягдлын нэгдсэн байгууламж	48.02	19,500.0
13.	Хаягдлын талбай	5.04	
14.	Хүдрийн овоолгын талбай	2.03	
15.	Шатахуун түгээх станц	0.39	
16.	Шимт хөрсний овоолго	2.92	
Нийт		117.44	



Зураг 2. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт

1.5.Төслийн одоогийн байдал

Төслийн одоогийн байдлаар Баянхөндий алтны төслийн бүтээн байгуулалтын ажил 2024 оны I-р улиралд эрчимжиж нарийвчилсан зураг төсөл болон загварчлалын ажлуудыг эцэслэж үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүдийг захиалах, барилга угсралтын ажлын хүрээнд үйлдвэрийн ган хийцийн угсралтын ажлуудыг эхлүүлсэн бөгөөд бүтээн байгуулалтын шатанд төслийн талбай дээр 2024 оны 12 дугаар сарын 14-ны байдлаар 26 компанийн 1227 ажилтан ажиллаж байна. Үүний 34 хувь буюу 412 ажилтан нь Баянхонгор аймгийн иргэд байна. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 2024 оны эцэст барилга, угсралтын ажлуудыг эцэслэж 2025 оны I улиралд улсын комисст хүлээлгэн өгч 2025 оны II улирал гэхэд анхны алтыг гаргахаар төлөвлөж ТЭЗҮ тодотголд оруулахаар тооцсон. Олборлолт болон үйлдвэрлэлийн шатанд бэлтгэх зорилгоор орон нутаг болон оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээнд хүнд машин механизмуудын сургалтанд орон нутгийн иргэдийг чадавхижуулах, тэдэнд мэргэжил эзэмшүүлэх, тогтвортой ажлын байраар хангах зорилгын хүрээнд 2023 онд 5 дугаар сараас хойш 8 удаагийн сургалтаар Баянхонгор аймгийн 164 иргэнийг сургалтанд хамруулж, чадамжийн гэрчилгээ олгосон. Тухайн иргэд нь мэргэжлээрээ Ухаа худаг уурхайд дадлагжин ажиллаж байгаа ба Баянхөндий төслийн олборлолт эхэлсэн үед үргэлжлүүлэн орон нутагтаа ирж ажиллах юм.

1.6. Хашаажуулалт

Талбайн эзэмшлийн талбайг тойруулж уурхайн тусгай зөвшөөрлийн талбайгаар тэгш өнцөгт хэлбэртэй хашааг барьж, нэвтрэх байр ба харуулын байрыг тохижуулсан. Хашаа нь төмөр торон сүлжээст, өргөн төрлийн, дунджаар 2м өндрийн стандартаар хийгдсэн. Тусгай хэрэгцээний харуул хамгаалалтын хашааг тухайлан зарим хэсэгт, боловсруулах үйлдвэр болон алт хайлуулах хэсгийг хамруулан байгуулахаар төлөвлөж байгуулсан.




Зураг 3. Төслийн талбайн хашаажуулалт

1.7. Уурхайн ажлын горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилд 350 хоног ажиллаж, 15 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар ТЭЗҮ-д тусгагдсан. Уурхай нь хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 11 цаг байна. Төслийн барилга угсралтын үйл ажиллагаа 2023 оны 7 дугаар сараас эхэлж өдрийн ээлж 11 цагаар ажиллаж байна.

1.8. Уурхайн ажилчдын хотхон

Уурхайн ажилчдын хотхоныг ордоос хойш 5 км зайд байгуулна. 2025 оны 3 дугаар сард 370 хүртэлх хүнийг хүлээн авах хүчин чадалтай орчин үеийн кемпийн байгууламж ашиглалтанд орно. Уг хотхонд гал тогоо, хоолны заал, спорт заал, лобби танхим, фитнес өрөө, утасгүй интернет кафе, амрах өрөөнүүд, агуулах, угаалгын газар, автогараж зэрэг уурхайн ажиллагсдын тав тухтай орчин бүрдүүлнэ. Мөн уурхайн ажилчдын орчин үеийн оффис барилга байгууламж тус хугацаанд ашиглалтанд орно. Оффист ажиллагсдын стресс тайлах өрөө, хоолны танхим, яаралтай тусламжийн тоноглол бүхий өрөө байх бөгөөд, яаралтай тусламжийн эмч 24 цаг бэлэн байдал хангаж ажиллана.



Зураг 4. Уурхайн хотхоны ерөнхий байдал

Уурхайн хотхон нь дараах бүрэлдэхүүн хэсгүүд багтана. Үүнд:

- Уурхайн ажилчдын кемп (200 өрөөтэй байгууламж, нийт 370 хүн байрлах хүчин чадалтай тохилог байр)
- Дулааны станц
- Нүүрсний ил агуулах
- Цахилгааны дэд станц
- Шалган нэвтрүүлэх байр
- Хогийн цэг
- Авто зогсоол
- Сагсны талбай
- Зам талбай
- Хоолны газар
- Хөнгөн тэрэгний граж
- Ундны усны цэвэршүүлэх байгууламж
- Шалган нэвтрүүлэх пост
- Хувцас угаалгын өрөө зэргүүд байна.

1.9. Хүдэр боловсруулах үйлдвэр


“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт Хөндий нэртэй газар орших Баянхөндийн алтны үндсэн ордоос 5 жилийн хугацаанд гадаад овоолготой, ил аргаар алт олборлоно. Ашиглалтын хугацаанд 40.05 сая тонн хөрс хуулалтын ажил хийж, хаягдал бохирдол тооцоогүй дүнгээр нийт 2.26 сая тонн исэлдсэн хүдэр, 0.51 сая тонн анхдагч

хүдэр, 5.32 сая тонн ядуу хүдэр (ядуу хүдэр гэж өнөөгийн эдийн засгийн нөхцөлд үр ашиггүй нөөцийг нэрлэсэн) олборлоно. Боловсруулах үйлдвэр нь жилд 600 мян.тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд нийт 10.3 тн алт ялган авахаар 2019 оны ТЭЗҮ-д тусгасан.



Зураг 5. Боловсруулах үйлдвэрийн план зураг

Баянхөндий болон Хар морь алтны үндсэн ордуудыг ил уурхайн аргаар боловсруулах үйлдвэрийг 10 жилийн хугацаанд жилд 650.0 тн хүдэр тэжээх төлөвлөгөөгөөр нийт 5.72 сая.тн хүдрээр хангана. Хүдэр тэжээлтийн төлөвлөгөөний алтны дундаж агуулга 3.11 г/т, мөнгөний дундаж агуулга 1.51 г/тн-тай хүдрийг уусган, дунджаар 92.72%-ийн алтны металл авалт, 55%-ийн мөнгөний металл авалттай нийт 16.478 тн алт, 4.737 тн мөнгө үйлдвэрлэнэ. Төслийн бүтээн байгуулалтын шийдвэрийг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр гаргаж, талбайд дараах ажлуудын төлөвлөн гүйцэтгэж байна. Хүдэр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, ордын уул техникийн нөхцөл, ордын геологийн тогтоц зэргээс хамааруулан уурхайн ашиглалтын жилүүдэд уулын цулын хэмжээг жигд байлгах зорилт тавин уулын ажлын календарчилсан төлөвлөгөөгөөр 7 жилийн хугацаанд ордыг ашиглахаар ТЭЗҮ тодотголт оруулахаар тооцон ажиллаж байна.



Зураг 6. Хүдэр боловсруулах үйлдвэрийн технологийн ерөнхий схем

1.9.1. Үйлдвэрийн одоогийн байдал

Төслийн бүтээн байгуулалтын шийдвэрийг 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр гаргаж, талбайд дараах ажлуудын төлөвлөн гүйцэтгэж байна.

- Нарийвчилсан загварчлалын ажлуудыг эцэслэж, урт хугацааны томоохон тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтууд хийгдсэн.
- Боловсруулах үйлдвэрийн ган хийцийн угсралт болон хагас өөрөө нунтаглах болон бөөрөнцөгт тээрмийн суурилуулалт хийгдэж байна.
- 2024 оны эцэст барилга, угсралтын ажлуудыг эцэслэж, 2025 оны 1-р улиралд улсын комисст хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна.
- Төлөвлөгөөний дагуу 2025 ондоо багтаан анхны алтыг гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Одоогоор бүтээн байгуулалтын явц нь энэ оны хоёрдугаар улирлын төгсгөлд боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 40 хувь, төслийн нийт бүтээн байгуулалтын явц 67 хувийн

гүйцэтгэлтэйгээр үргэлжилж байгаа бөгөөд дийлэнх бүтээн байгуулалтаа эцэслэхээр ажиллаж байна.



Зураг 7. Үйлдвэрийн барилгийн ажлын явц

1.9.2. Үйлдвэрийн технологийн горим

Ил уурхайгаас ирүүлсэн анхдагч хүдрийг 1 шатны бутлалт, 2 шатны нунтаглалт, ангилалт болон уусгалт шингээлтийн СІР технологиор баяжуулж, десорбци электролизийн процессоор алтыг ялгаж авна. Хүдэр боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлыг стандарт шаардлагын дагуу саармагжуулж кек хэлбэрээр нэгдсэн хаягдлын сан /IWF/-д хуурай хэлбэрээр хуримтлуулна.

Бутлалт: Уурхайгаас ирсэн хүдрийг хүдэр хүлээн авах бункерийн дээр байрлах үл хөдлөх шигшүүр дээр өөрөө буулгах автомашинаар буюу утгуурт ачигчаар авчирч буулгана. Жижиг ширхэг нь доош бункерт орох ба шигшүүрийн дээрх хэсгийг тусгай талбайд овоолж жижиглэнэ. Бункерээс хавтант тэжээгчээр дамжин ирсэн хүдрийг анхдагч PE600*900 маркийн хацарт бутлуураар бутална.

Хацарт бутлуурын хүлээн авах хүдрийн хамгийн том хэмжээ -350 мм, бутлагдан гарах хүдрийн ширхэглэл $P_{80}\%$ нь -110 мм хүртэл бутлагдан туузан конвейероор тээвэрлэгдэн бутлагдсан хүдрийн бункерт орно. Бункерээс туузан конвейероор дамжин бутлагдсан хүдрийн овоолгыг давхар үүсгэх бөгөөд туузан конвейерийн тусламжтайгаар хагас өөрөө нунтаглалтын тээрэм рүү тэжээгдэнэ. Бутлах хэсэг хэвийн бус ажиллах, онцгой нөхцөлд бутлагдсан хүдрийн нөөц овоолгоос утгуурт ачигчаар сэргээх тэжээгүүрийн тусламжтайгаар нунтаглалтын хэсгийг тэжээнэ.


Нунтаглалт: Бутлагдсан хүдэр нь анхан шатны ХӨН тээрэмд хүдрийг P₈₀ нь 1500 μм хүртэл нунтаглаж нунтагласан бүтээгдэхүүн нь 2 мм тортой чичиргээт шигшүүрт шигшигдэнэ. Шигшүүрийн дээрх хүдэр нь эргэлтийн ачаалал (20%) болж тээрэмд тэжээгдэнэ. Шигшүүрийн доорх хүдэр нь багц гидроциклоноор ангилагдана. Ангилагчийн элс нь хоёр дахь шатны бөөрөнцөгт тээрэм рүү эргэлтийн ачаалал (300%) болж дахин нунтаглагдана. Тээрэмд хүдрийг P₈₀ нь 60 μм хүртэл нунтаглаж, багц гидроциклоны тэжээлийн зумпфид хуримтлуулна. Уг зумпфнаас нунтаглагдсан бүтээгдэхүүнийг зутангийн насосоор шахаж багц гидроциклоныг тэжээх ба ангилагчийн халиаг уусгалтын хэсэг рүү зутангийн насосоор тэжээнэ.

Уусгалт: уусгалтын хэсэгт булинга өтгөрүүлэгчид 42%-ийн хатуулагтай булингыг тохируулж, цианид натри ашиглаж 4 чанд уусгалт явуулах ба уусгалт нийт хугацаа 36 цаг орчим үргэлжилнэ. Хүдрийг цианидаар уусгах явцад баримтлах аюулгүйн чухал алхам бол уусмалын рН-ийн түвшин юм.

Цианиджуулалт: Цианидыг ашиглан алт уусгах арга нь алт, мөнгийг сонгомол хэлбэрээр уусгах чадварт үндэслэгдсэн. Хэдийгээр хорт чанар нь анхаарал татах асуудал боловч процессыг сайн дэг журамтай зохион байгуулсан тохиолдолд хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай. Энгийн цианидын давс буюу натрийн цианид нь усанд уусаж диссоциацлагдан тухайн металлын давс, чөлөөт цианидын ионыг үүсгэдэг.




Натрийн цианид нь алтны үйлдвэрлэлд хамгийн түгээмэл хэрэглэгддэг. Цианидын ион нь усанд гидролизод орж устөрөгчит цианид болон гидроксил ионыг үүсгэдэг:



Цианжуулалтын үед алт нь хүчилтөрөгчөөр исэлдэж улмаар [Au(CN)₂]⁻ гэсэн комплекс анионы байдлаар уусмалд шилжинэ. Энэ урвалыг дараах байдлаар илэрхийлнэ.



Адсорбцийн процесс: Уусгалтын процессын үр дүнд сул (алтны агуулга 1-20 гр/тн) уусмалыг гаргадаг. Шингээлтийн процесс нь дараах урвалын дагуу явагдана.



Адсорбцийн процесст идэвхжүүлсэн нүүрс ашиглах бөгөөд нүүрсэнд алт шингээх процесс урвуу чиглэлтэй байна. Уусмал дахь алт идэвхжүүлсэн нүүрсэнд суусны дараа шингээлтийн багана доторх ядуу уусмал нь ядуу уусмалын танк руу насос руу орно. Баян нүүрсийг даралттай

усаар тээвэрлэж, десорбцийн хэсгийн нүүрс хүчлээр угаах чанд өгнө. Ядуу уусмалыг хаягдлын өтгөрүүлэгчид шахахын өмнө нүүрсний шигшүүрээр хянана. Хаягдлын өтгөрүүлэгчээс гарсан элс нь саармагжуулах чанд тэжээгдэнэ. Өтгөрүүлэгчийн халиа нь уусгалтын хэсэгт эргэлийн ачааллаар дахин уусгалтад орно.

Идэвхжүүлсэн нүүрс нь нүх, сүвэрхэг шинж чанартай, маш идэвхтэй гадаргуутай. Шингээлтийн процесст оруулах булингын хатуулаг маш чухал бөгөөд уусгалтын процесст идэвхжүүлсэн нүүрсэнд алтыг шингээн баяжсан нүүрсийг зутангаас нүүрсний шигшүүрээр ялган авч десорбцийн хэсэгт дамжуулна. Шингээлтийн хэсэгт 6 чан ашиглах ба нүүрсний агууламж 30 г/л байна.

Шингээлтийн эхний чанаас дараа дараагийн чанд уусмал нь өөрийн урсгалаар урсаж нүүрсэнд алтаа шингээж ядуу уусмал болно. Идэвхжүүлсэн нүүрсийг урсгалын эсрэг шилжүүлж сүүлчийн чанд дахин сэргээсэн нүүрсээр ачаална.

Десорбцийн процесс: Десорбцийн процесс нь шингээлтийн урвуу процесс бөгөөд цианидын уусмалаас шингээсэн алтыг салгахад дараах урвал явагдана.



Десорбцийн процесст нөлөөлөх хамгийн гол хүчин зүйл нь температур бөгөөд температур ихсэхийн хэрээр цэвэрлэгээ сайжирдаг. Баяжсан нүүрсэнд дунджаар 3000 гр/тн алт байхад 625 гр/тн мөнгө агуулагдахаар байна.




Нүүрснээс алтыг салгаж авахын өмнө түүнээс кальци, магнийн давсуудыг зайлуулахын тулд нүүрсийг тусгай саванд азотын болон давсны хүчлийн 3-5% уусмалаар угааж, усаар зайлж цэвэрлэнэ. Хүчлээр угаах болон усаар цэвэрлэсний дараа нүүрсийг десорбцийн баганад даралттай усаар дамжуулан оруулна. Десорбцийн процессыг 10%-ийн натрийн шүлтийн, 120-150⁰С халуун уусмалаар 0.5 МРа өндөр даралтад явуулах ба нүүрсэнд шингэсэн алт нь уусдаг цианидын комплекс хэлбэрээр уусмал байдалд орж нүүрснээс сална. Десорбцийн тоног төхөөрөмж нь 3 тн идэвхжүүлсэн нүүрс агуулах багтаамжтай хүчлээр угаах болон AARL (Anglo American Research Laboratory)-ийн даралтат десорбцийн колониудаас бүрдэнэ.

Десорбцийн процессоос гарсан алтаар баяжсан баян уусмал нь алтны өрөөнд байрлах электролизийн өмнөх тэжээлийн саванд хуримтлагдана. Суларсан нүүрсийг десорбцийн савнаас устай хамт шигшүүрээр шигшиж нарийн ширхэгтэйг нь ялгаж хаях ба том хэсгийг нь сэргээх зууханд оруулна. Сэргээх зууханд нүүрсийг 650-750⁰С хэмд халааж, органик хольцоос нь цэвэрлэснээр алт шингээх гадаргуугийн идэвхийг дахин сэргээдэг. Зуухнаас гарсан халуун нүүрсийг хүйтэн усаар хөргөөд уусгалт шингээлтийн хэсгийн сүүлийн чанд өгч циклд оруулна. Энд шаардлагатай тохиолдолд нүүрсийг халаан идэвхжилийг 95% хүртэл сэргээнэ.

Электролизийн процесс: Электролиз буюу цахилгаан химийн процессоор уусмалын алт катод дээр сууж, уусмал ядуу агуулгатай болж гарах ба энэ уусмалыг цахилгаан соронзон насосоор шахагдан, замдаа дахин халаагчаар халж десорбцийн баганад орох замаар десорбци-


электролизийн процесс битүү циклээр явагдана. Электролизийн үндсэн урвалууд дараах байдлаар электродууд дээр явагддаг.

Үндсэн уусмалын урвал:




Катод дээр:


1. Алтны ионууд багасаж алтны атомууд болно.



2. Устөрөгч ялгарна.




3. Хүчилтөрөгч багасна.





Анод дээр:

1. Ус исэлдүүлж хүчилтөрөгч бий болгоно.



2. Цианид исэлдэж аммони ба нүүрсхүчлийн давхар исэл гарна.



Электролиз явж байх үед шинээр уусмалд ямар нэгэн бодис нэмэхгүй. Электролизийн процессын үед үнэт металтай уусмалд $Au(CN)_2^-$ байх ба алт катод дээр бууна. Үүнтэй зэрэгцээд катод дээр ус ангижирч ялгарна. Анод дээр хүчилтөрөгч ялгарч ион исэлдсэнээс CO_2 ба N_2 ялгарна.

Хайлуулалтын процесс: уусмалыг электролизийн онгоцнуудад цахилгаан соронзон насосоор шахах ба уусмал дах алт ган хөвөн катод дээр ялгарч сууна. Алт суусан ган ноосыг 600-650⁰С температурт хатаах шүүгээнд хатааж исэлдүүлсний дараа хайлах зууханд 800-950⁰С температурт зууханд хайлуулж алтан гулдмай гарган авна.

Мөнгө салгах арга аргачлал: Уусмалаас мөнгийг салгаж авахад хамгийн хямд болон хялбар арга нь мөнгөний хлорид /AgCl₂/-ийн тунадас үүсгэх юм. Үйлдвэрлэлд техникийн эсвэл хүнсний давс хэрэглэнэ. Электролизийн процессоос гарах катодод суусан алт нь алт болон бусад металлын өндөр хольцтой байна. Үүнээс алтны баяжмал салгаж авсны дараа үлдсэн уусмал нь олон төрлийн металлын өндөр агуулгатай байдаг. Уусмалыг шахуурга болон хавхалганы оролцоотойгоор задаргааны танк руу өгч урьдчилан тогтоосон хэмжээгээр давс /NaCl/ нэмж хутгагчийг ажиллуулна. Мөнгөний хлоридын тунадас үүсэх процесс дараах урвалаар явагдана.

Хаягдал саармагжуулах: уусгалтын хэсгээс гарах ядуу уусмалын 42%-ийн хатуулагтай хаягдлын өтгөрүүлэгчид флокулянтын тусламжтайгаар өтгөрүүлэн, өтгөрүүлэгчийн халиа нь эргэлтийн усны чанд хуримтлагдан процесст орно. Өтгөрүүлэгчээс гарсан 50%-ийн хатуулагтай хаягдлыг саармагжуулах хэсгийн чанд гэжжэнэ. Боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлыг стандарт шаардлагын дагуу SO₂/Агаар технологийн аргаар саармагжуулна.

Саармагжуулсан хаягдлыг фильтр прессээр шүүн шахаж гаргасан 15%-ийн чийглэгтэй хатуу хаягдлыг нэгдсэн хаягдлын сан /IWF/-д хуримтлуулна.

1.9.3. Лаборатори

Үйлдвэрийн дэргэдэх лабораторийн үйл ажиллагааг “АЛС Групп” ХХК-тай хамтран явуулахаар төлөвлөсөн. 2023 онд ALS Limited компанийн Монгол дахь салбар болж, дэлхий даяар уул уурхайн болон хайгуулын салбарт үйлчилгээ үзүүлдэг үндсэн компаниудын нэг болж арилжааны туршилт шинжилгээ, орчин үеийн дээд зэргийн тоноглолтой иж бүрэн лабораторитой металл, хүдэр болон хатуу түлшний шинжилгээ судалгаа, хөндлөнгийн хяналтын чиглэлээр үйл ажиллагаа амжилттай явуулж байна.

Үйлдвэрийн дэргэдэх лаборатори нь үйлдвэрийн бүх шатны эрдэс химийн сорилт, шинжилгээ, судалгаа гүйцэтгэж, анхдагч хүдэр, хаягдал болон баяжмалын чанарыг тодорхойлох, хүдэр боловсруулах технологийн явцыг шалгах, сайжруулах, тохируулга хийж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажиллах явцыг шинжлэн судлах, сорьц боловсруулна. Технологийн шат дамжлагуудаас ирсэн сорьцыг шинжилж, цаг тухайд нь үр дүнг боловсруулна.

Туршилтын хэсэгт эрдэс бодис тодорхойлогч, бутлах, нунтаглах, шигшин ялгах, дээжийг боловсруулах зэрэг холбогдох тоног төхөөрөмжүүдийг суурилуулна. Лабораторид 30 орчим нэр төрлийн урвалж, бодис ашиглах бөгөөд хэрэглээг ТЭЗҮ-ний тодотголд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

1.9.4. Химийн бодис

Химийн бодисоос үүдэлтэй аюул осол нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл өндөртэй. Лабораторид 30 орчим нэр төрлийн урвалж, бодис ашиглах бөгөөд хэрэглээг ТЭЗҮ-ийн тодотголд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

"Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах үйл ажиллагаа явуулах иргэн, хуулийн этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.1 дүгээр зүйлийн 1.1.14 дэх заалт, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай" гэж заасний дагуу БОННУ-нд тусгагдсан 15-н химийн бодисийг ашиглах тусгай зөвшөөрлийн хүсэлтийг БОУАӨЯ-нд гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Химийн хорт болон аюултай бодисын үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах “Химийн бодисын аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө”-г боловсруулан мөрдөж ажиллана. Мөн “Хорт бодисын тухай хууль”, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, эрүүл мэндийн яам болон онцгой байдлын ерөнхий газрын хамтарсан 28/40/29 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Химийн аюултай болон хорт бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах болон устгах тухай” журам болоод бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн ажиллана.

Төлөвлөгөөт онд химийн бодис ашиглах холбогдох баримт бичгүүд, зөвшөөрлүүдийг авахаар төлөвлөж ТЭЗҮ-ийн тодотголд тусган оруула.

Эрдэнэ Монгол ХХК нь цианидыг тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах тусгай журам боловсруулж холбогдох байгууллагуудаар батлуулан мөрдөн ажиллана. Тус үйлдвэр ашиглалтад орсноор химийн бодисын үндсэн гурван хэсэгт химийн урвалж бодис ашиглана.

Үүнд:

- Үндсэн лабораторид
- Үйлдвэрийн технологид
- Хяналт шинжилгээний лабораторид
- Хаягдал саармагжуулах хэсэгт хэрэглэх урвалж гэсэн хэрэглэгчид үүснэ.

Хүснэгт. БОННУ-нд тусгагдсан 15-н химийн бодисийн жагсаалт


Химийн бодисуудын жагсаалт							
№	Химийн бодисын нэр /Монгол/	Химийн бодисын нэр /Англи/	CAS number	Томьёо	Ашиглах зориулалт	Зарцуулалт, кг/тн	Жилийн хэрэглээ, тн, ширхэг
1	Шохой	Quick Lime	1305-78-8	CaO	Уусмалын орчин тохируулах	0.98	291.3
2	Натрийн цианид	Sodium Cyanide	143-33-9	NaCN	Алтны хүдэр уусгах	0.32	95.6
3	Натрийн гидроксид	Sodium Hydroxide	1310-73-2	NaOH	Уусмалын орчин тохируулах	0.36	107.5
4	Флокулянт	Flocculant		AN934 SH	Өтгөрүүлэх	0.12	35.8
5	Натрийн метабисульфид	Sodium Metabisulphite (SMBS)	7681-57-4	Na2S2O5	Хаягдал хүдэр дэх цианидыг задлан саармагжуулах	0.80	239.0
6	Давсны хүчил	Hydrochloric Acid /37%/	7647-01-0	HCl	Идэвхижүүлсэн нүүрс цэвэрлэх	0.56	167.3
7	Зэсийн сульфат	Copper Sulphate	7758-98-7	CuSO4	Хаягдал хүдэр дэх цианидыг задлан саармагжуулах	0.16	47.8
8	Идэвхижүүлсэн нүүрс	Activated Carbon		C	Алт шингээх	0.02	6.0
9	Бура	Borax /99%/	1330-96-4	Na2B4O7	Алт хайлуулах	0.30	89.6
10	Цахиурын исэл	Silica	112945-52-5	SiO2	Алт хайлуулах	0.30	89.6
11	Натрийн карбонат	Soda Ash	497-19-8	Na2CO3	Алт хайлуулах	0.20	59.7
12	Калийн нитрат	Potassium Nitrate /99%/	7757-79-1	KNO3	Алт хайлуулах	0.05	14.9
13	Сульфамын хүчил	Sulphamic Acid	5329-14-6	H3NSO3	Десорбци хэсэг	0.00017	0.1
14	Азотын хүчил	Nitric acid /68%/	7697-37-2	HNO3	Фильтр цэвэрлэх	0.17	50.8
15	Антикслант	Antiscalant			Шугам хоолойн цэвэрлэгээ		0.5

1.9.5. Урвалж бодисын агуулах

Урвалж бодисын агуулах нь үйлдвэрийн зүүн хойд талд байрлуулахаар төлөвлөсөн. Агуулахын талбайн хашаан дотор зүүн урд талд цианидын агуулах, хашааны зүүн хойд талд хүчлийн агуулах барихаар төлөвлөж байна. Мөн тус хоёр агуулахын хооронд аюултай хог хаягдлын агуулах байгуулахаар төлөвлөжээ. Талбайн баруун хойд талд шүлтлэг/уусгах материалын агуулах барихаар төлөвлөж байна.

1.9.6. Хаягдлын нэгдсэн сан


Боловсруулах үйлдвэр нь цианидаар (CIP) алтны хүдрийг уусгах ба жилд 650.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай. Боловсруулах үйлдвэрээс гарах хаягдал нь фильтр пресс буюу шүүн шахах төхөөрөмжөөр ороод 410.0 мян.м³/жил хуурай хаягдал гарах ба хаягдлыг автосамосвалд ачиж, тээвэрлэн хаягдлын нэгдсэн санд буулгаж, хураана. Ил уурхайн хөрс болон боловсруулах үйлдвэрийн хаягдлыг “Хаягдлын нэгдсэн сан”-д буулгаж хураана. Өнгөрсөн онд хяналтын 7 цооног өрөмдсөн. Цооногийн түвшиний хяналтыг сар бүр хийж, улиралд 1 удаа усны чанарын шинжилгээг хийхээр төлөвлөгөөнд тусгасан. Төлөвлөгөөт онд хяналтын 3 цооног өрөмдөх ажлыг гүйцэтгэнэ. Хаягдлын нэгдсэн сангийн 2-р жилийн ажлыг хийхээр төлөвлөж байна.



1.10. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг ашиглах шороон орд

Төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай дайрга, элс, шаврыг төслийн талбайн ойр орчмоос ашиглахаар төсөлд тооцлоо. Хүдэр боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж, хаягдлын нэгдсэн сангийн суурийн талбайн байгуулалт, бусад барилга байгууламжийн

барилгын ажилд түгээмэл тархацтай ашигт малтмал шаардлагатай бөгөөд үүнд элс, хайрга, дайрга, шавар орж байна. Төслийн хувьд дээрх түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгааг хийж, зарим орд газрыг нээж илрүүлэн нөөцийг тогтоосон. Дайрга, шавар, элсний орд газар нь Хөндийн талбайн ашиглалтын лицензийн талбай дотор байрлаж байна. Төсөл нь эдгээр орд газруудаас дэд бүтцийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтад шаардлагатай шавар, дайрга болон элсийг ашиглана.




Зураг 8. Хөндий төслийн талбайд байрлах түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газруудын байршил


Ил уурхайн олборлолтын үеийн хаягдлын тооцоог хийхдээ ил уурхайн хүрээнд өртөж буй барилгын материалын ордуудын ил уурхайн нөхцөлд тулгуурлан хаягдлыг 10 см байхаар тооцоход олборлолтын үеийн хаягдал дунджаар 1.0% байхаар тооцсон ба бохирдлыг практик болон зөвшөөрөгдөх хэмжээнд буюу дунджаар 1.5% байхаар тооцон авсан болно. Тойг болон Төвийн дайргын ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц нийт 1,332.43 мян.м³, Ангийн шаврын ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц нийт 274.73 мян.м³ тус тус байхаар ТЭЗҮ-ийн тодотголд тусгасан.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг ашиглах шороон орд, хүчин чадал


Ил уурхайн хүчин чадал нь уурхайн ашиглалтын жилүүдэд уулын цулын хэмжээг жигд байлгах, ил уурхайн хүрээ хязгаарт өртсөн нөөцийг бүрэн ашиглах гэсэн үндсэн нөхцөлүүдээс бүрдэх бөгөөд нийт түгээмэл тархацтай ашигт малтмалын хэмжээ 553.31 мян.м³ байна. Ил уурхайн хүчин чадлыг уул техникийн нөхцөл, бүтээн байгуулалтын ажлын хэрэгцээ шаардлага, техник тоног төхөөрөмжийн бүтээмж зэрэгт үндэслэн 174 мян.м³ байхаар төлөвлөсөн.



Зураг 9. Тойгийн дайрганы ил уурхайн 3 хэмжээст загварчлал



Зураг 10. Төвийн дайрганы ил уурхайн 3 хэмжээст загварчлал



Зураг 11. Ангийн шаврын ил уурхайн 3 хэмжээст загварчлал

1.11. Уурхайн нээлт

Монгол Улсын “Ашигт малтмалын тухай” хуулийн 27 дугаар зүйл буюу “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг”-д ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь:


- 27.1.1. тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах;
- 27.1.8. ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор уурхайн талбайд нэвтрэн орох, дамжин өнгөрөх, шаардлагатай барилга байгууламж барих, түүнийг ашиглах; 27.1.11. холбогдох хууль тогтоомжийн дагуу газар, ус ашиглах эрх эдэлж, үүрэг хүлээнэ гэж заасан байдаг.

“Эрдэнэ Монгол” ХХК нь “Ашигт малтмалын тухай” хуулийн дээрх зүйл, заалтууд болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд холбогдох тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр өөрийн эзэмшлийн MV-021444 тоот дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж олборлолтод бэлтгэж байна.

Уурхайн нээлтийг 2025 онд эхлүүлэхээр төлөвлөсөн ба ил уурхайн 1-р үе шатаас эхлэх ашиглалтын эхний жил хийгдэх нээлтийн ажлаар шимт хөрс хуулалт, хөрс хуулалт болон уулын бэлтгэл ажлууд хийгдэнэ. Уурхайн зүүн урд хэсгээс траншей нэвтрэлтээр нээнэ. Нээх траншей нэвтрэлтийн өргөн нь 20 м байх ба урт нь 63 м, налуу нь 100 промилль, эзлэхүүн нь 3.0 мян.м³ байхаар ТЭЗҮ тодотголд тусгахаар төлөвлөсөн. Ил уурхайн ашиглалтын эхний жил алтны хүдрийн гарштай талаас ил уурхайн нээлтийг хийх бөгөөд 2.40 сая.м³ уулын цул олборлож, үүнээс хөрс хуулалт 2.10 сая.м³, хүдэр олборлолт 0.78 сая.тн байна. Ил уурхайн гүнзгийрэлт д.т.д 1210 м байна. Олборлох 0.78 сая.тн хүдрийн 0.33 сая.тн хүдэр нь ЭЗҮА-тай (алтны дундаж агуулга 3.82 гр/тн, мөнгөний дундаж агуулга 1.36 гр/тн), 0.44 сая.тн хүдэр нь ядуу агуулгатай (0.1-0.35 гр/тн), 0.01 сая.тн хүдэр нь ТНЭЗҮА-тай (0.35-0.45 гр/тн) хүдэр тус тус байна.

Ил уурхайн ашиглалтын эхний жил алтны хүдрийн гарштай талаас ил уурхайн нээлтийг хийх бөгөөд 2.40 сая.м³ уулын цул олборлож, үүнээс хөрс хуулалт 2.10 сая.м³, хүдэр олборлолт


0.78 сая.тн байна. Ил уурхайн гүнзгийрэлт д.т.д 1210 м байна. Олборлох 0.78 сая.тн хүдрийн 0.33 сая.тн хүдэр нь ЭЗҮА-тай (алтны дундаж агуулга 3.82 гр/тн, мөнгөний дундаж агуулга 1.36 гр/тн), 0.44 сая.тн хүдэр нь ядуу агуулгатай (0.1-0.35 гр/тн), 0.01 сая.тн хүдэр нь ТНЭЗҮА-тай (0.35-0.45 гр/тн) хүдэр тус тус байхаар ТЭЗҮ тодотголд тусган оруулахаар төлөвлөсөн.



Зураг 12. Ил уурхайн ажлын хамгийн бага талбай бэлтгэх схем

1.11.1. Тэсэлгээний ажил

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Баянхөндий алтны үндсэн ордод түшиглэн үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн байнгын түгээх агуулах байгуулан, тус уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд шаардлагатай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах, түгээх, олгох зорилго тавин ажиллана. Төлөвлөгөөт онд уурхайн нээлтийн үйл ажиллагааг эхлүүлэх үед 2.10 сая.м³ хөрсөнд тэсэлгээ хийхээр ТЭЗҮ тодотголд тусган оруулахаар төлөвлөсөн. Баянхөндий усан хангамжийн системийн II үе шатны барилга угсралтын ажил эхэлбэл тэсэлгээний ажил гүйцэтгэнэ.



Зураг 13. Ил уурхайн ашиглалтын 1-р жилийн дэвсгэр зураг

1.11.2. Агуулах

Агуулах: Агуулах нь хийцлэлийн хувьд төмөр ган карказтай 150 мм сэндвичэн хавтантай, дотор талын хана 120 мм тоосгон 24x24 харьцаатай барилга байна. Барилга нь дараах бүтэцтэй байна.

- Материал хүлээн авах хэсэг
- Ажлын талбарууд
- Хувцас солих хэсэг

Хүснэгт. Агуулахын бүтэц

Д/д	Бүтэц	Хэмжээ, м ²	Тайлбар
1	Агуулах	513.4	Материалыг 14 хоногийн нөөцлөлтийн хугацаатай хадгална
2	Ажлын талбар	69.2	Механик, цахилгааны өрөөнүүд байна
3	Хувцас солих	5.04	4-8 хувцасны шүүгээ байрлана

Агуулахын тоноглолууд нь:

- Материалыг буулгах талбай, агуулахын тавиур, тусгай шалтай,
- Дотоод хяналтын камержуулалттай,
- Материал нөөцлөлт, хүргэлт, хангалтын нэгдсэн бүртгэлийн системтэй,
- Агааржуулалтын систем
- Төвлөрсөн дулааны станцаас хангагдах халаалтын системтэй,
- Гал унтраагуур тус тус байна.




Зураг 14. Бараа, материалын агуулахын төлөвлөлт

ШТС, ГТБ-ын агуулах: Төслийн үйл ажиллагаанд шаардлагатай шатахууныг “Шунхлай трейдинг” ХХК-ний Баянхөндий төсөл дээрх түр агуулахаас авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Шатахуун түгээх агуулах руу орох гарах гарцтай, агуулахын хүчин чадал нийт 150м³ багтаамжтай. Шатахуун агуулах савны 70 хувьд нь шатахууныг орлогодож авдаг.

- Шатахууны тасалгаатай 1-р сав 20м³, 2-р сав 30м³ багтаамжтай.
- Шатахууны 3-р сав 50м³ багтаамжтай.
- Шатахууны 4-р сав 50м³ багтаамжтай.




Тэсрэх бодисын агуулах: Тэсрэх материалын агуулах болон тэсрэх материал хадгалах, бэлтгэх зориулалт бүхий байр нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм болон стандартын дагуу доторлож, тоноглож, төхөөрөмжилсөн байна. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн байнгын түгээх агуулахууд нь тэсрэх материал тавьж олгох байрнаас 20 метр зайд байх бөгөөд агуулахын хамгаалалтын хашаанаас тэсэлгээний аюулгүй ажиллагааны шинэчилсэн дүрмийн дагуу 30 метрээс багагүй /энэхүү зайг уулархаг газар төслөөр ойртуулж болно гэж заасан байдаг/ зайд нийт 5200 орчим м² талбайг эзлэн орших ба хүн ам төвлөрсөн суурин газар, авто зам, эрчим хүчний шугамаас зайтай байхаар тооцож төлөвлөсөн. Агуулахын барилгын ажил төлөвлөгөөт онд үргэлжилнэ.



Зураг 15. Агуулахын талбайн ерөнхий төлөвлөгөө

1.12. Хүнд хөнгөн машин механизмын засвар

Уурхайн засвар, техникийн үйлчилгээний хэсэг нь уул–тээврийн машин, тоног төхөөрөмж, бусад туслах тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор техникийн үйлчилгээ, урсгал засвар, дунд засвар хийх, засварын ажилд шаардлагатай аливаа материал, сэлбэг хэрэгсэл, түлш, тос, тосолгооны материал зэргийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, олгох зориулалттай. Хүнд, хөнгөн машин механизмын засвар нь тоног төхөөрөмжийн урсгал засварыг гүйцэтгэхдээ сэргээх ба бэлэн эд ангийг ашиглан засвар, үйлчилгээг хийнэ. Ашиглалтын үйлчилгээний өндөр түвшин, материал техникийн хангамжийн найдвартай системээр уурхайд ажиллаж байгаа бүх тоног төхөөрөмжийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангахад үндэслэн засвар, техник үйлчилгээний ажлыг зохион байгуулна. Хүнд, хөнгөн машин механизмын засвар нь уурхайгаас зүүн урд зүгт 0.4 км зайд байрлана. Өдрийн 2 ээлжээр, ээлжид 11 цагаар ажиллана.




Зураг 16. Хүнд, хөнгөн машин механизмын засварын газрын 3D план

1.13. Шатахуун түгээх станц

Уурхайн шатах тослох материалын жилийн дундаж хэрэглээ нь дизелийн түлшинд 3,000 тн, дизелийн масло 50 тн, бусад төрлийн шатах тослох материал 7 тн тус тус байна. Шатах тослох материалын 1 сарын нөөцтэй байхаар бодож түлш хадгалах 100 тн–ын багтаамжтай ган сав 10 ширхэг, дизелийн масло болон бусад материалыг зориулалтын савтай нь тус тус хадгалахаар төсөлд тусгасан байна. ШТС нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Операторын барилга 4.0x8.0м. Автомашин цэнэглэх талбай руу харсан удирдлагын өрөөтэй,
- Насос станц 7.0x4.8м. Барилгын гадна ханыг L50x5 булан төмөр зангидаж, гадна өнгөлгөө нь металл хавтантай байхаар тусгасан,
- Шатахууныг хадгалах сав. Тус ШТС-д ДТ хадгалах зориулалтын тус бүр 100м³ багтаамжтай 10ш хэвтээ савыг газар дээр суурилуулна. 10м³ багтаамжтай 1ш хэвтээ цилиндр ган савыг газар доор далд байрлуулахаар төлөвлөв. Савнаас түгээгүүр лүү зарлага гаргах зориулалттай,
- Түгээгүүрүүд нь тээврийн хэрэгсэл мөргөх, шлангаас чирэхэд эвдрэх, шатахуун асгахаас хамгаалсан хамгаалалттай,
- Болзошгүй ослоор шатахуун буулгах болон шатахуун цэнэглэх талбайд асгарсан шатахууныг цуглуулах зорилгоор 10м³ багтаамжтай 1ш хэвтээ сав, шугам хоолой дахь шатахууныг суллах зорилгоор 10м³ багтаамжтай 1ш хэвтээ сав газар доор суурилуулахаар төлөвлөв,
- Автоцистернээс буулгах төхөөрөмж,
- Галын усан сан,
- Зам талбай дээрх түлш хүлээн авах газрыг барихдаа асгарсан түлшийг цуглуулах цементэн шалтай хийгдэнэ.



Зураг 17. Шатахуун түгээх станцын зохион байгуулалт

Түүнчлэн аюулгүй ажиллагаа, байгаль орчинд ээлтэй байх технологийн шийдлүүдийг нарийн төлөвлөж өгсөн байна. Түлш ханган нийлүүлэгч компанитай удаан хугацааны гэрээ хийх буюу хамгийн ойр байрлах түлшний агуулах бүхий шатахуун түгээгүүрээс авто машинаар уурхайн талбай руу татна. Шатахууны хэрэгцээг улирлаас хамаарч нийлүүлнэ.

1.14. Цахилгаан хангамж

Баянхөндий алтны үндсэн ордыг Баруун бүсийн эрчим хүчний системээс хангах боломжгүй бөгөөд төслийн цахилгааны хэрэглээг найдвартай хангахын тулд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийн сухайт дэд станцаас 110 кВ-ын 242 км ЦДАШ-аар цахилгаанаар хангахаар тооцсон. Тус цахилгаан хангамжийн эх үүсвэр нь 2025 оны 4-р сард ашиглалтад орох бөгөөд бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.



Зураг 18. Баянхөндий-Нарийнсухайт 110 кВ-ын ЦДАШ-ын трасс

Төслийг цахилгаанаар хангах Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас Баянхонгор аймгийн Шинэжинст сум хүртэл 110кВ-ын 242 км цахилгаан дамжуулах агаарын шугам 110/11 кВ-ын 2*16 МВА чадалтай Баянхөндий дэд станц, 2*2750 кВА чадалтай дизель генератор, 7.7 км урттай 11 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг М-Си-Эс Интернэйшл ХХК гүйцэтгэж байна.



Зураг 19. Баянхөндий-Нарийнсухайт 110 кВ-ын ЦДАШ

Цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгчид нь:

- Ил уурхайн хэрэглэгчид (ус таталтын насосууд);
- Боловсруулах үйлдвэрийн хэрэглэгчид;
- Уурхайн хотхоны хэрэглэгчид;

- Засварын газрын хэрэглэгчид;
- Уурын зуухны хэрэглэгчид эдгээр болно.

Боловсруулах үйлдвэрийн хувьд тээрмүүд нь 6 кВ-ын цахилгаан эрчим хүчээр харин бусад хэрэглэгчид нь 0.4 кВ –ын цахилгаан эрчим хүчээр хангагдана. Боловсруулахүйлдвэрийн дизель цахилгаан үүсгүүрээс засварын газар болон уурхайн хотхон хүртэл 6 кВ –ын А-35 маркийн утастай 3.2 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам татахаар ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. ТЭЗҮ-ийн тодотголд орсон цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил төлөвлөгөөнт онд үргэлжлэн явагдана.

1.14.1. Төслийн цахилгаан хангамж


Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт байрлах Нарийн сухайт дэд станцаас салбарлуулан 110 кВ-ын ЦДАШ татах нь бүс нутгийн эрчим хүчний систем, нийгэмд ихээхэн ач холбогдолтой төсөл болох юм. Тус цахилгааны шугам нь төслийг бүрэн эрчим хүчээр хангахаас гадна зэргэлдээ орших сум болон сууринуудыг тодорхой хэмжээний цахилгааны хэрэглээг хангах боломжтой. Төслийн хүрээнд дараах цахилгаан хангамжийн өргөтгөл болон тоноглолын ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Нарийн сухайт-Баянхөндийн төсөл хүртэл 242 км урттай 110 кВ-ын 1 хэлхээт ЦДАШ татах,
- Баянхөндий дэд станцаас ажилчдын хотхон хүртэл 7.7 км урттай 11 кВ-ын ЦДАШ татах,
- 110/11 кВ-ын Баянхөндий дэд станц байгуулах,
- Нарийнсухайт 110/35/6 кВ дэд станцын өргөтгөлийг тус тус барьж байгуулан 2025 оны 4-р сард ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Боловсруулах үйлдвэрийн туршилт тохируулгын үед болон аваарын үед цахилгааны хэрэглээг 2750 кВА-ийн 2 ширхэг дизель генератораар хангана.

1.15. Бохир ус цэвэрлэх байгууламж

Ажилчдын кемпийн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж нь хоногт 80 м³ хүчин чадалтай, харин уурхайн бохир ус цэвэрлэх байгууламж нь хоногт 40 м³ хүчин чадалтай тус тус байна. Байгууламж нь 17.6x5.4 м хэмжээтэй, газраас доош 2 давхар, төмөр бетон бүтээцтэй барилга байна.



Зураг 20. Бохир ус цэвэрлэх байгууламж


1.16. Уурхайн дулаан хангамж

Уурхайн барилга байгууламжуудын халаалтыг уурын зуухаар халаахаар төлөвлөсөн. Уурхайн барилга байгууламжуудын баригдсан материал хийц зэргийн тусгай шаардлагуудын дагуу халаалтыг өгнө. Халаалтын усны дундаж температур 95~70; халаалтын систем нь түгээлтийн болон буцалтын ус битүү хэлхээнд байхаар зохион байгуулагдсан байна.

Боловсруулах үйлдвэрийн анхдагч, дунд бутлалт болон нунтаглалтын цех, уусган баяжуулалт, шүүн шахах цехүүдэд халаалтын шулуун хоолойт радиатор тавьж суурилуулна. Уурхайн үйлдвэрийн үндсэн барилга, уурхайн хотхон зэрэг бусад барилга байгууламжуудад стандарт ширмэн радиаторууд суурилуулна.

Бие даасан дулаан хангамжийн тооцоог хийхдээ халаалтын улиралд гадна агаарын тооцооны температурыг -30°C , барилга доторх тооцооны температурыг $+18^{\circ}\text{C}$ байхаар тооцсон. Халаалт үргэлжлэх хугацааг 194 хоног байхаар тооцов. Урьдчилсан тооцоогоор нийт дулааны халаалтын ачаалал 2878 кВт, хэрэглээний халуун усны дулааны ачаалал 92 кВт орчим байх гарчээ.

Үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангахад инженерийн хангамж болох дулаан, ус, харилцаа холбоо ихээхэн үүрэгтэй. Уурын зуухны барилга нь боловсруулах үйлдвэр болон оффисын дэргэд байрлах бөгөөд 36м*24м харьцаатай 7.6 метрийн өндөртэй нэг давхар байгууламж байх бөгөөд уурын зуухыг жил бүрийн 10-р сарын 1-ээс 5-р сарын 10-ны хооронд ажиллуулахаар төлөвлөсөн ба төлөвлөгөөнт онд барилгын ажил үргэлжилнэ.



Зураг 21. Уурын зуухын зохион байгуулалт

1.16.1. Уурын зуухны буюу бойлерын байгууламж

Үйлдвэрийн бойлерын байгууламж нь халаалтын системд 70-95°C халуун ус өгнө. Боловсруулахүйлдвэрийн талбай дахь бойлерын байгууламжид 1 ширхэг DZL2.8-1/115/70-АП маркийн бойлер суурилуулна. Энэхүү бойлерын байгууламжийн боловсруулсан халуун усны гол хэрэглээ барилгын дулаацуулгын радиаторт өгөгдөнө. Сүлжээний өгөх, буцах усны температур 115/70 °C. Уурхайн оффисын байр, цайны газар, амралтын байр, ажилчдын барилга, Боловсруулахүйлдвэр зэрэг уурхайн халаалт шаардлагатай бүхий л хэрэглэгчдийг нийт 2 уурын зуухаар халаана.

1.17. Усан хангамж

Уурхайн усны хэрэглээг хангах зорилгоор 2019 онд гүйцэтгэсэн газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны үр дүнд Хүрэнцавын талбай, Хүрэнцавын зүүн талбай, Шинэ кемпийн талбай гэсэн усжилт өндөртэй 3 талбайг ялгаж газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн C зэргээр 10 л/с хэмжээгээр тогтоосон. Усны газрын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 158 тоот дүгнэлтэд төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах 861.58м³/хон усыг нийт 10 л/сек буюу 950.4м³/хон газрын доорх усны орд болон шүүрлийн усыг хуримтлуулан хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэж дүгнэсэн.

Төслийн талбайд гидрогеологийн хайгуул, судалгааны дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

- 2012 онд “Ар Пи Эс Акватерра” ХХК нь өмнөх судалгааны ажлуудын мэдээлэл дээрээ үндэслэн гидрогеологийн хайгуулын иж бүрэн хөтөлбөрийг Шинэжинстийн бассейнд хэрэгжүүлэн, гүний 5, бага болон дунд гүний 9, мониторинг, туршилтын 7 цооног, 1 худаг тус тус өрөмдсөн байна.

- 2017 оноос “Охь Ус” ХХК нь газрын доорх усны эрлийн гидрогеологийн судалгааны ажлуудыг гүйцэтгэж, 2018 онд гидрогеологийн 6 цооног өрөмдөж шавхалт туршилтын ажил явуулсан байна.
- 2018 онд “Охь Ус” ХХК-иар Баянхөндий ордын гидрогеологийн нөхцөлийг тодорхойлох судалгааг сонгосон талбайн хэмжээнд 150 м гүнтэй 3 ширхэг цооног өрөмдсөн.
- 2023 онд “Охь Ус” ХХК-иар 2018-2019 оны эрэл-хайгуулын ажлын үед өрөмдсөн хайгуул-ашиглалтын цооногуудад 14-30 хоногийн хугацаатай тогтмол ундаргатай туршилтын шавхалтууд гүйцэтгэжээ.


Дээрх хайгуулын ажлаар хийгдсэн өрөмдлөгийн бичиглэл болон урьд өмнө хийгдсэн гидрогеологийн хайгуулын хөтөлбөрүүдэд тулгуурлан төслийн талбай орчмын хэсгийг хамарсан буюу ордын илүү гүний хэсгүүд болон ойр орчмын аллювийн хурдасууд зэрэг хэд хэдэн ус хангамжийн эх үүсвэрийн нөөц бололцоо бүхий газруудыг тогтоосон байна. төлөвлөгөөт онд гидрогеологийн хайгуулын ажил үргэлжилнэ.

1.17.1. Ус хангамжийн эх үүсвэр

Гидрогеологийн хайгуулын судалгааны ажлын хүрээнд үйлдвэрийн усны хэрэглээг хангах зорилгоор хайгуул ашиглалтын 61.5-200 метрийн гүнтэй 18 ширхэг цооног өрөмдсөн. Дараах хүснэгтээр ус хангамжийн эх үүсвэр, гүний худгийн мэдээллийг оруулав.

Хүснэгт 6. Гүний худгуудын мэдээлэл

№	Үе шат	Гүний худаг	Гүн, м	Ундарга, л/сек
1		BKW-21	66	0.8
2	I	BKW-48	200	3.4
3		BKW-54	61.5	4.8
4		NCW-01	102	1
5		BKW-16	92	1
6	II	BKW-30	90	2.2
7		BKW-44	90	1.8
8		BKW-46	150	2.4
Нийт				17.4



Зураг 22. Ус хангамжийн системийн схем

1.17.2. Уурхайн кемпийн унд, ахуйн усны хэрэгцээ

Уурхайн кемпэд дунджаар хоногт 408 хүн байрлах бөгөөд тус ажилчдын тоо уурхайн хүчин чадлаас хамааран жил бүр өөрчлөгдөж байна. Нэг хүнд оногдох унд-ахуйн усны хэрэглээг 150 л/хон-оор тооцсон ба тус нормыг 2015.07.31-ийн БОНХАЖЯ-ны сайдын тушаалаар баталсан байдаг.

Кемпийн унд-ахуйн усны хэрэглээнд 18,604.5 м³ ус хэрэглэхээр төлөвлөгөөнт онд ТЭЗҮ-н тодотголд орохоор төлөвлөсөн. Уурхайн кемпийн ахуйн усны хэрэглээг NCW-01 худагас хангах ба 100 м³-ын багтаамжтай усан санд хэрэглээний усыг хуримтлуулна.

1.17.3. Замын тоос дарах усалгаа

Уурхайн зам усалгаанд ашиглах 20 тонн багтаамжтай усны машины бүтээлийн тооцоонд үндэслэн орд ашиглалтын хугацаанд зам усалгаанд шаардагдах усны хэрэглээг тооцов. Баянхөндий алтны үндсэн ордын олборлолтын шороон замын усалгаа болон барилгын ажлын үеийн тоосжилт дарахад зарцуулна. Уурхайн 4.4-6.5 км шороон замын 88900-129680 м² талбайг

жилд (180 хоног буюу 4-р сарын 1-ээс 10-р сарын 1 хүртэл услах) 32,004-46,685 м³ ус зарцуулна.

1.17.4. Боловсруулах үйлдвэрийн усны хэрэглээ

Төслийн хамгийн том усны гол хэрэглэгч нь боловсруулах үйлдвэр юм. БОНХАЖ-ын Сайдын А/301 дугаар тушаалын “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу 1тн хүдэр уусган баяжуулахад шаардагдах технологийн усны хэрэгцээ нь 3м³ бөгөөд жилд 1516218-1905852м³ усыг боловсруулах үйлдвэрт ашиглахаар тооцоо гарч байна. ТЭЗҮ-ийн тодотголд үйлдвэрийн ашиглалтын нийт хугацаанд 18.02 сая.м³ технологийн ус хэрэглэх бөгөөд үүнээс 16.79 сая.м³ буюу 93.15%-ийг эргүүлэн ашиглах ба нэмж өгөх цэвэр ус 1.24 сая.м³ буюу жилд дунджаар 123.5 мян.м³ цэвэр ус хэрэглэх бөгөөд хамгийн ихдээ 4.84 л/сек-ийн ундарга шаардлагатай байгаагаар төлөвлөнө.

1.17.5. Биологийн нөхөн сэргээлт

Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дүгээр тушаалын 13 дугаар хавсралт. Цэцэрлэг, зүлэг ногоо услах нормын дагуу тооцож үзэхэд биологийн нөхөн сэргээлтэнд нийт 54528 м³ ус ашиглахаар байна.

1.18. Тээвэрлэлт

Улаанбаатар хотоос төслийн талбай хооронд төслийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа хүн тээвэр (977 км), хүнс тээвэр (947 км), ачаа тээвэр (975 км) гэсэн 3 маршрутаар хийгддэг. Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Замын чиглэл тогтоох тухай” А/396 дугаар захирамжаар батлагдсан чиглэлээр тээвэрлэлтийг гүйцэтгэж байна (**Error! Reference source not found.** “Замын чиглэл тогтоох тухай” захирамж).

1.18.1. Хүн тээвэр

Баян Хөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр нийт 400 ажлын байр бий болох ба 30-40 хувийг орон нутгийн иргэдээс бүрдүүлнэ. Үүнтэй холбоотой хүн тээврийн хэрэгслүүд Улаанбаатараас Баянхонгор хотын төв хүртэл хатуу хучилттай замаар (640 км), Баянхонгороос Шинэжинст сумын төв хүртэл хатуу хучилттай замаар (38 км), сайжруулсан шороон замаар (217 км), Шинэжинст сумаас төслийн талбай хүртэл 100 орчим км шороон замаар дамжин очно.

1.18.2. Хүнс тээвэр

Улаанбаатараас Баянхонгор хотын төв хүртэл хатуу хучилттай замаар (640 км), Баянхонгороос Шинэжинст сумын төв хүртэл хатуу хучилттай замаар (38 км), сайжруулсан шороон замаар (217 км), Шинэжинст сумаас төслийн талбай хүртэл 100 орчим км шороон замаар дамжин очно. Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Замын чиглэл тогтоох тухай” А/396 дугаар захирамжаар батлагдсан чиглэлээр тээвэрлэлтийг гүйцэтгэж байна.

1.18.3. Ачаа тээвэр

Улаанбаатараас Баянхонгор хотын төв хүртэл хатуу хучилттай замаар (640 км), Баянхонгороос Шинэжинст сумын төв хүртэл хатуу хучилттай замаар (38 км), сайжруулсан шороон замаар (217 км), Шинэжинст сумаас төслийн талбай хүртэл 100 орчим км шороон замаар дамжин очно. Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Замын чиглэл тогтоох тухай” А/396 дугаар захирамжаар батлагдсан чиглэлээр тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

Олон салаа зам гаргах, замыг өргөсгөх, тоосжилтоос сэргийлэх зорилгоор ачаа тээврийн батлагдсан дагуу шаардлагатай цэгүүдэд замын тэмдэг тэмдэглэгээг байршуулахын зэрэгцээ жолооч нарт тогтоосон маршрутын дагуу тээвэрлэлт хийхийг тогтмол анхааруулж, тогтоосон маршрутаас өөр замаар зорчсон тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажилладаг. 2025 оны 4 дүгээр сараас ачаа тээврийн хөдөлгөөний эрчим эрс багасна.



Замын чиглэл тогтоох тухай

Аймгийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Шинэжинст сумын Засаг даргын 2024 оны 168 дугаар албан бичиг, “Эрдэнэ Монгол” ХХК-ний 2024 оны 215/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн санал, хүсэлтийг харгалзан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.8, 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Баянхонгор аймгийн төв – Шинэжинст сумын төв” чиглэлийн орон нутгийн чанартай шороон авто замын төгсгөлөөс эхлэн Баянхөндий төслийн хүн, хүнс, шатахуун болон барилгын түр ачаа тээврийн чиглэлийг нэгдүгээр, солбицлын цэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тогтоосон чиглэлийн дагуу замыг тэмдэгжүүлэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, замын арчлалтыг тогтмол гүйцэтгэн хүн, мал амьтан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, тоосжилтыг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, орчны бохирдол үүсгэхгүй тээвэрлэлт хийхийг “Эрдэнэ Монгол” ХХК (А.Билгүүн)-д үүрэг болгосугай.

3. Замын чиглэл тогтоосонтой холбогдуулан иргэд, олон нийтэд сурталчлан мэдээлэхийг Шинэжинст сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ)-д, авто зам, хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр), Авто зам (тээвэр)-ын хяналтын Улсын ахлах байцаагч (М.Магвансүрэн) нарт, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Д.Содномсамдан)-д тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.




W:\2024 ON\Zakhiramj\Захирамж+++.Docx 624010905

Зураг 23. “Замын чиглэл тогтоох тухай” захирамж

1.18.4. Дотоод зам

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбай доторх хүн тээвэр, хөнгөн тэрэг зорчих болон барилгын материал зөөх зориулалт бүхий 7.9 км урт сайжруулсан шороон замын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар боловсруулж, гүйцэтгэж байна.



Зураг 24. Төслийн дотоод замын трасс болон хөндлөн огтлол

1.18.5. Агаарын харилцаа

Баянхонгор аймгийн “Баянхонгор” нисэх буудалд 2024 оны 7-р сард 3С ангиллын аэродромын хөөрч, буух хучилттай зурвасын 21,800 м² хучилтын ажлыг дуусгасан бөгөөд удаан хугацаанд зогсолттой байсан нислэг сэргэж тогтмол хуваарийн дагуу нислэг үйлдэх боломжтой болж байгаа юм. Компанийн лицензийн талбай дотор стандартад нийцсэн нислэгийн зурвас байгуулах төслийн ажил 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн явагдаж байгаа бөгөөд төлөвлөгөөт хугацаанд дуусгахаар төлөвлөж байна.

Төсөлд зориулан агаарын тээврийн боломжит тооцоо судалгаа хийсэн бөгөөд төсөл хэрэгжилтийн явцад нисэх зорчигчдын тоо, хүний нөөцийн төлөвлөгөө зэрэгт тулгуурлан нисэх

буудлын барилга байгууламжийн судалгаа явуулсан байна. Тус судалгаанд тийрэлтэт хөдөлгүүртэй Фоккер-50, СААБ-340 болон МИ-171 нисэх онгоцнуудыг урьдчилсан байдлаар сонгосон. Фоккер-50 нисэх онгоц нь:

- 56 хүртэл хүний суудалтай
- 500 км/ц хурдтай
- 76.2 м өндөрт нисэх
- 1,110 орчим км зам туулах
- Нисэх онгоцны 11-13 дахь ангилалд орно.

Хөндий төсөл нь Улаанбаатар хотоос авто замаар 1000 км, агаарын замаар 698 км зайд байрладаг. Баянхонгор-Улаанбаатар чиглэлийн агаарын нислэгийг “Геосан” ХХК гүйцэтгэж байна. Тус нислэг нь 9 хүний суудалтай онгоц явж байна.

1.19. Холбоо харилцаа

Уурхайн талбайд интернет харилцаа холбооны найдвартай байдлыг хангах үүднээс үндэсний үүрэн телефоны оператор “Юнител” ХХК-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд төслийн талбай дээр тус үүрэн телефоны операторын сүлжээ бүрэн орсон. Холбоо харилцаа, цахилгаан хангамжийн тоноглол нь 3 хэсэгт байршина. Үүнд:

- Уурхайн кемп болон төв оффис
- Хүдэр боловсруулах үйлдвэр
- Хүнд, хөнгөн машин механизмын засвар


Уурхайн дотоод холбоонд боловсруулах үйлдвэрийн операторууд, экскаватор, өрмийн машин, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана. Уурхайн бүсэд сансрын антен суурилуулж телевизийн сувгууд хүлээн авна.

1.20. Хүний нөөцийн бодлого

Баянхонгор аймаг нь 20 сумтай бөгөөд ойролцоогоор 88,166 хүн амтай ба үүнээс 2,565 орчим иргэн нь Шинэжинст сумд оршин суудаг. Төсөл хэрэгжиж буй Шинэжинст сумын хувьд 1956 онд байгуулагдсан бөгөөд Зараа, Уртын гол, Эрдэнэшанд, Эхэн хавцгай гэсэн 4 багтай бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь сум орон нутагтай хуулийн хүрээнд хамтран ажиллах зорилгоор нийт ашиглалтын 10 жилийн хугацаанд хамгийн ихдээ 469 ажилчид ажиллах бөгөөд 30 орчим хувийг орон нутгаас бүрдүүлэхээр ажиллаж байна.

Төсөлд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах ажлын хүрээнд “Энержи ресурс” ХХК-тай хамтран хүнд машин механизмын операторын сургалтыг 2023 оны 05 сараас хойш 8 удаа зохион байгуулж, Баянхонгор аймгийн 17 сумын 160 иргэнийг сургалтад хамруулж, чадамжийн гэрчилгээ олгоод байгаа бөгөөд одоогийн байдлаар 105 иргэн Ухаа худаг уурхайн мэргэжлээрээ дадлагажин, туршлага хуримтлуулан ажиллаж байна. Тухайн иргэд төслийн

олборлолтын үйл ажиллагаа эхэлсэн үед “Эрдэнэ Монгол” ХХК-руу шилжин орон нутгаасаа үргэлжлүүлэн ажиллана.



Зураг 25. Эрдэнэ Монгол ХХК, байгууллагын бүтэц, зохион байгуулалт 2025

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1.Физик газарзүй

Физик газарзүйн мужлалын хувьд Монгол Алтайн их мужид, газарзүйн хэлбэр гадаргуугийн хэв шинжээр уулс хоорондын хөндийн хэв шинжид багтаан үздэг. Газрын гадаргын хувьд 1850-2010 м өргөгдсөн мөлгөрдүү оройтой намхан толгодтой, эдгээр нь өөр хоорондоо 25-40 метрийн өргөн хуурай сайраар тусгаарлагдсан, элэгдэл хуримтлалын рельеф зонхилно (Ш.Цэгмид 1967 он). Ашиглалтын талбай нь Эдрэнгийн нурууны зүүн төгсгөлд оршино.

2.2.Уур амьсгал

Ашиглалтын талбайн нутаг дэвсгэр нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай. Агаарын урсгал үүсэхэд уул зүйн нөхцөл болон орон нутгийн бичил салхи нөлөөлж, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар, зундаа халуун дулаан, өвөлдөө хахир хүйтэн нөхцөлтэй бичил бүс нутгийг бүрдүүлдэг. Өвлийн улиралд цас бага ордог бөгөөд агаар нь хуурайвтар, чийг багатай, харин хавар салхи шуурга ихтэй, зарим үед 40 м/сек-ээс их хурдтайгаар шуурдаг. Үнэмлэхүй бага температур нь -37.4°C , үнэмлэхүй их температур нь 44.9°C хүрдэг бөгөөд үнэмлэхүй их, бага температурын агууриг нь (82.3°C) эрс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь 0.7°C , хамгийн хүйтэн 01 сарын дундаж температур -15.5°C байхад хамгийн дулаан буюу 07 сарын дундаж температур 16.8°C байдаг.

2.3.Гадаргын ус

Хөндий тусгай зөвшөөрөлтэй талбай нь Алтайн өвөр говийн сав газарт багтах бөгөөд энэ сав газар дахь ихэнх голдрил нь түр урсацтай, жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайг түр урсацтай, хуурай сайрууд дайран өнгөрөх бөгөөд эдгээр сайрууд зун, намрын эрчимшил ихтэй хур борооны үед түр урсацтай болдог.

2.4.Газрын доорх ус

Баянхөндийн талбай нь гидрогеологийн дүүрэгчлэлээр улирлын хомс тэжээлтэй Монголын Өмнөдговийн хэсгийн дэд мужид багтана. Харин төслийн ойр орчмын дэвсгэр талбай нь Монгол орны гидрогеологийн мужлалаар (Н.Жадамбаа ба болон бусад, УБ 1988) хувирмал, терриген, вулканоген чулуулгаас бүрдсэн антиклиналь атираажилтай гидрогеологийн массивт хамаарна. Төслийн үйл ажиллагаа эрчимжиж эхэлсэн 2023 оны II улирлаас эхлэн улирал бүр үйлдвэрлэлийн зориулалтаар ус авч байгаа худгуудын усанд тогтмол шинжилгээ хийлгэж байна.

Усны чанарын 2019, 2022 - 2024 онуудын шинжилгээний үр дүнгээр Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд кальци, хлор, сульфат, ерөнхий хатуулаг, стронци, Хүрэнцав, Өргөө, Босго, Майхан хүрэнгийн хойд худгуудад магни, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Хүрэнцав, Майхан хүрэнгийн хойд, Босго худгуудын усанд никель, Майхан хүрэнгийн хойд худгийн усанд молибден,

Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгуудын усанд төмрийн агууламж тус тус Ундны усны стандарт (MNS 0900:2018)-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан байна.

Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд хлор, сульфат, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Гүн заг, Майхан хүрэн урд, хойд худгуудын усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгийн усанд төмөр гэсэн элементүүд тус тус Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 6148:2010) стандартаас тус тус давсан үзүүлэлттэй байна.

2.5.Хөрсөн бүрхэвч

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбай орчмын бүс нутагт цөлийн бор саарал хөрс зонхилон тархсан. Төслийн талбай орчимд тархсан бор саарал хөрс нь элсэнцэр, хэврэг бүтэцтэй, үржил шим багатай, эмзэг хөрс тархсан.

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайд ил уурхай, гадаад овоолгууд, Боловсруулахүйлдвэр, уурхайн үйлчилгээ, хангамжийн барилга байгууламжуудыг 117.44 га талбайд байгуулахаар төлөвлөсөн. Барилга байгууламжуудыг барихаас өмнө хөндөгдөх талбайн өнгөн хөрсийг хуулж шимт хөрс хадгалах талбайд байршуулна. Нийт хөндөгдөх талбайгаас 0.8 тн ялзмагийн агууламжтай 228.4 мян.м³ шимт хөрс хуулагдана. Шимт хөрсний овоолгын үржил шимийг тогтвортой байлгах зорилгоор орой болон хажууг ургамжлуулна. Энэхүү шимт хөрсийг уурхайн ашиглалтын хугацаанд болон хаалтын үе шатанд эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд ашиглана.

2.6.Ургамлан нөмрөг

Баянхөндий ордын байрлаж буй бүс нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Алтайн өвөр говийн цөлийн тойрог, цөлийн хээрийн бүсэд хамаарагддаг. Ургамалжилтын хувьд сийрэг, чулуут цөлийн хэвшинжид хамаарна. Энэ тойргийг ургамлын зүйлийн бүрдлийн хувьд их ядмаг боловч Алашаа говиос арай илүү гэж үздэг. Тус ордын талбайд гүйцэтгэсэн 3 удаагийн хээрийн судалгаагаар 57 зүйл ургамал тэмдэглэгдсэн бөгөөд ургамлын зүйлийн бүрдэлд сөөг, сөөгөнцөр (бүйлс, зээргэнэ, хармаг, хотир, бударгана, ортууз гэх мэт) зонхилсон. Мөн 2 зүйлийн мод (сухай, заг), 1 зүйлийн хагас шимэгч (Цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо) болон олон наст өвслөг ургамлууд ургадаг. Үүнээс гадна тухайн жилийн хур тундасны хэмжээнээс хамааран ургадаг эсвэл өнждөг нэг наст ургамлууд тохиолдоно.

Тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн байгаль орчны судалгаануудаар 57 зүйл ургамлаас нэн ховор 3 зүйл (Регелийн будраа, Толбот бэрээмэг, Потанины Хотир), ховор 2 зүйл (Монгол бүйлс, Өргөст ортууз) бүртгэгдсэн. Харин цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо Майхан хүрэнгийн худгаас Цэнхэр Номин орох зам дагуу загийн ёроолоор шимэгчлэн ургадаг.

2.7.Амьтны аймаг

Баянхөндий төслийн талбай нь бүхэлдээ ГИДЦГ-ын А хэсгийн Орчны бүсэд хамаарагдах тул нэн ховор, ховор зэрлэг амьтад, шувуудын байршил нутагтай давхцахаас гадна 10-20 км-

ийн ойр байрладаг. Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд хөхтөн амьтдаас хар сүүлт, махчдаас чоно, үнэг шавж идэштнээс зараа, мэрэгчдээс алаг даага, шар чичүүл, бор шигшүүхэй жигүүртнээс цэгцгий, сар, хэрээ, хулан жороо, тас, цөлийн чогчиго мөлхөгчдөөс хонин ба нохой гүрвэл, сум могой тархсан.

2.8.Нийгэм - Эдийн засаг

Төслийн талбай нь манай орны дэд бүтэц сул хөгжсөн бүс нутагт байрлана. Хүн амын суурьшил маш багатай. Гол төлөв Халх ястан амьдардаг бөгөөд сумын хүн амын 90 орчим хувь нь мал аж ахуй эрхэлдэг. Хөндий талбай нь Шинэжинст, Баян-Өндөр сумдаас 130 орчим км зайтай оршино. Хамгийн ойр орших Шинэжинст сум нь талбайгаас 85 км-т байдаг бөгөөд энэ сум нь 2015 онд төвийн нэгдсэн цахилгаан сүлжээнд холбогдсон. Хүн эмнэлэг, холбооны салбартай, 9 жилийн дунд сургууль, ШТС-тай. Тээврийн үндсэн төрөл нь автомашин бөгөөд харилцдаг бүх газруудтайгаа шороон замаар холбогдоно. Шинэжинст сумын унд ахуйн усыг цэнгэгжүүлэх байгууламж, ус хангамжийн системд урвуу осмосын системийг нэмэлтээр суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор худаг гаргаж Шинэжинст сумд хүлээлгэн өгсөн.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ҮНДСЭН БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 дугаартай “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн барилгын үе шатны үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн хураангуйг доорх хүснэгтэд тоймлон үзүүлэв.

Хүснэгт 7. Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр				
	Барилгажилтын үе шат				
	Барилга байгууламж барих талбайн хөрс хуулалт	Зам ашиглалт/Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	Барилгын материал тээвэрлэх, хадгалах, ашиглах	Барилга байгууламж, түр суурин барих	Хог хаягдал цуглуулах, устгах талбай байгуулах
Газрын гадарга, хэвлий					
Үндсэн					
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 117.44 га газрын гадарга эвдрэлд орж, гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх, байгалийн үзэмжийг доройтуулах	Т	Т	Т	Т	У
Болзошгүй					
Уурхайн ажилчдын хотхоноос гарсан хог хаягдал, уурхайн бусад барилга байгууламжуудын хатуу хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээр тухайн орчны газрын гадаргыг бохирдуулах					У
Уур амьсгал					
Үндсэн					
Энэ төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс жилд хамгийн ихдээ 61,599 тн нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг дээр дурдсан хэмжээгээр нэмэгдүүлнэ.		Д			
Агаарын чанар					
Үндсэн					
117.44 га эвдэгдсэн талбайгаас цагт 39.24 кг тоос дэгдэн агаарын чанарт нөлөөлнө. Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.		Б			
Тээврийн хэрэгслүүд болон дизель цахилгаан генераторуудаас жилд 61599 тн нүүрстөрөгчийн хий ялгарна.		Б			
Гадаргын ус					
Үндсэн					

Ил уурхай, хүдрийн овоолго, авто зам байгуулснаар Хүрэн цавын сайрын голдирол өөрчлөгдөх				Б	
Шимт хөрсний овоолго, авто зам, автомашины зогсоол, ШТС, дулаан хангамжийн байгууламж, хаягдлын нэгдсэн байгууламж, хаягдлын талбайг байгуулснаар сайрын голдирол өөрчлөгдөх				Б	
Газрын доорх ус					
Үндсэн					
Газрын доорх усны тэжээмжийн талбай багасах				Б	
Болзошгүй					
Химийн бодисоор бохирдсон ус асгарч алдагдаж болзошгүй;			б		
ШТМ асгаралт бий болж болзошгүй.		б			
Хөрсөн бүрхэвч					
Үндсэн					
Ил уурхайг ашиглах, барилга байгууламжуудыг барих явцад хөндөгдөх 117.44 га талбайгаас 0.8 тн ялзмагийн нөөц бүхий 320.4 мян.м3 шимт хөрс хуулагдана.	У			Д	
Болзошгүй					
ШТМ алдагдсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох		Д			
Ашиглалт дууссан аккумуляторын шингэн, Боловсруулах үйлдвэрт ашиглаж буй химийн бодис гоожиж, асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.					Б
Ургамлан нөмрөг					
Үндсэн					
Барилгажилтын үе шатанд уурхайн овоолго, зам бусад дэд бүтцийн барилга байгууламжийг байгуулах 39.26 га талбайгаас 4 хэв шинжийн ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдана.	б	б	б	б	
Болзошгүй					
Барилгажилтын үеийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, газар хөндөх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурч, ургамлан нөмрөг доройтох.	б	б	б	б	
Ашиглалтын үед ил уурхай, хөрсний овоолгуудаас салхиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилтын улмаас ургамлан нөмрөгийн фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурснаар, ургамлын биомасс багасах.					У
Амьтны аймаг					
Болзошгүй					
Барилгын газар шорооны ажлын үед шувуудын үүр устгах, тэр дундаа Жороо тоодог (<i>Chlamydotis undulata</i>), Хулан жороо (<i>Podoces hendersoni</i>)	б	б	б	б	
Барилгын ажилтнууд хууль бус ан хийх		б	б	б	
Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас зэрлэг амьтад тэр дундаа нүүдлийн том туруутан амьтад (хар сүүлт зээр) дайжсанаар амьдрах орчноо шууд бусаар алдах		б	б	б	
Тусгай хамгаалалттай газар нутаг					

Болзошгүй				
Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тэсэлгээ хийх зэргээс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар Говийн их ДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд тархан амьдрах амьтад үргэж дайжих		б		
Дуу шуугиан, доргион чичиргээ				
Үндсэн				
Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс дуу шуугиан үүсэж, уурхайн 419 ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.		б		
Нийгэм эдийн засаг				
Болзошгүй				
Баянхөндийн алтны үндсэн ордын ашиглах бүх үе шатанд барилгын материал, хүнс, хүн тээвэрлэх маршрутаар тээврийн хэрэгслүүд зорчих явцад үүссэн тоосжилт, дуу шуугианаас ойролцоо нутаглаж буй малчдад тавгүй байдал үүсэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.		Т		

Нөлөөллийн эрчим		Нөлөөллийн үргэлжлэх хугацаа		
		Т	Түр зуурын	1 сар хүртэл
	Их	б	Богино	сар хүртэл
	Дунд	Д	Дунд	1-3 жил хүртэл
	Бага	У	Урт	Төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл
		Б	Байнгын	Хаалтын дараа ч үргэлжлэх

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

4.1. Зорилго, зорилт

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2021 онд “Эко трейд” ХХК-ний боловсруулсан “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг, амлалт, Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан зэргийг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

4.1.1. Баримтлах зарчим

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, холбогдох төрийн захиргааны байгууллагын тусгай дансанд төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Эрдэнэ Монгол” ХХК байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

4.1.2. Хамрах хүрээ

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 дугаартай “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбайд 2025 онд дараах барилгуудыг барьж, 49,566м² талбайн ил уурхайгаас 710,673 тн буюу 268,178 м³ хөрс хуулж, 10,000 тн хүдэр олборлож, 34,863м² талбайд 348,632м³ эзэлхүүнтэй хөрсний овоолго, 41,549м³ шимт хөрсний овоолго үүсгэх ба геологи, хайгуулын ажил үргэлжлэн 20,000 т.м өрөмдлөг, 4,000 м суваг нэвтрэлтийн ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна. Гэсэн хэдий ч эдийн засаг, хил гаалийн хүндрэл, бэрхшээл болон бусад урьдчилан таамаглах боломжгүй асуудлууд төслийн үйл ажиллагаанд нөлөөлж болох тул 2025 онд төлөвлөсөн уул, барилга, хайгуулын ажлуудад өөрчлөлт орж болзошгүй юм.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд төслийн дэд бүтцийн барилга, байгууламжийн бүтээн байгуулалтад буюу технологийн болон орон нутгийн тээврийн авто зам байгуулах, барилга, хаягдлын далангийн суурь зэрэгт хайрга, дайрга, шавар ашиглах зорилгоор хайгуулын ажлыг 2023 онд хийж гүйцэтгэн, Тойг, Төв болон Хүрэнцавын дайргын орд, Бор ухаагийн сайрын элс, хайрганы холимог орд, Ангийн шаврын ордыг тус тус илрүүлсэн. Тус хайгуулын ажлын үр дүнгээр тайлангаар Тойгийн дайргын ордын хэмжээнд 580,196 м³, Төвийн дайргын ордын хэмжээнд 1,399,214 м³, Ангийн шаврын ордын хэмжээнд 392,089 м³, Хүрэнцавын

дайргын ордын хэмжээнд 106,937 м³, Бор ухаагийн сайрын элс, хайрганы холимог ордын хэмжээнд 293,824 м³ нөөцийг 2024 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, Тойг, Төв, Ангийн ордуудын нөөцийг бүртгүүлсэн.

Төслийн бүтээн байгуулалт 2024 оны сүүлийн улирлын байдлаар 67%-тай байна. Төсөл хэрэгжих хугацаанд дараах объектууд нэгдсэн цогцолбор байдлаар баригдаж төслийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх юм. Үүнд:

4.1.3. Төслийн барилга байгууламж

Төслийн талбай дээрх барилга байгууламж, тэдгээрийн байршил орд ашиглах хугацаанд дараах объектууд нэгдсэн цогцолбор байдлаар баригдана. Үүнд:

- Захиргааны барилга
- Шатахуун түгээх станц
- Тэсрэх материалын агуулах
- Ажилчдын кемп
- Хүнд, хөнгөн машин механизмын засварын хэсэг
- Боловсруулах үйлдвэр
- Агуулахын аж ахуй гэх мэт объектууд баригдах юм.

4.1.4. Ил уурхайн хэсэг

- Ил уурхай (Баянхөндий, Хар морь алтны үндсэн ордууд, Барилгын материалын ордууд)
- Хаягдлын нэгдсэн сан (Хөрсний гадаад овоолго ба хаягдлын овоолго)
- Шимт хөрсний овоолго
- Уурхайн дотоод технологийн зам
- Хүдрийн овоолго
- Тэсрэх материалын агуулах
- Хүнд, хөнгөн машин механизмын засвар
- Шатахуун түгээх станц

4.1.5. Боловсруулах үйлдвэрийн хэсэг

- Удирдлагын байр
- Хүдэр бэлтгэх хэсэг
- Хүдэр боловсруулах үйлдвэр
- Химийн лаборатори
- Химийн бодисын агуулах
- Харуулын байр
- Уурын зуух
- Цэвэрлэх байгууламж

4.1.6. Ажилчдын кемп

- Нэвтрүүлэх байр
- Захиргаа
- Ажилчдын сууц
- Аж ахуйн агуулах
- Хоолны газар
- Уурын зуух
- Цэвэрлэх байгууламж

Хүснэгт 8. 2024 онд баригдсан барилгын ажлын гүйцэтгэл, 2025 онд барихаар төлөвлөсөн барилгын ажил

Д/д	Барилга байгууламж	Хүчин чадал	Талбайн хэмжээ /м ² /	Эзэлхүүн /м ³ /	Барьж эхэлсэн огноо	Барьж дуусах огноо	Гүйцэтгэл
1. Түр барилга байгууламж							
1.1	Ерөнхий гүйцэтгэгчийн түр оффис	55 хүн	480	1,216	2023.09.04	2023.12.13	100%
1.2	Захиалагчийн түр оффис	30 хүн	250	985	2023.09.05	2023.11.10	100%
1.3	Ажилчдын модуль кемп	160 хүн	1,500	4,350	2023.07.06	2023.12.03	100%
1.4	Гэр кемп	30 гэр	-	-	2023.07.06	2023.07.13	100%
1.5	Барилгын талбайн ариун цэврийн байгууламж	5 суултуур 4 угаалтуур 7 хөтөвч	24.7	68.1	2023.08.06	2023.08.09	100%
1.6	Гэр кемпийн түр ариун цэврийн байгууламж	5 суултуур 7 угаалтуур 8 хөтөвч	24.7	68.1	2023.07.21	2023.09.04	100%
1.7	Ангаран агуулах	1200 м ³	310	1,210	2023.07.14	2023.11.27	100%
1.8	Контейнер агуулах	40 тн	30	72	2023.07.08	2023.07.21	100%
1.9	Ажилчдын хоолны ангар	150 хүн	407	1,400	2023.07.06	2023.10.12	100%
1.10	Бэлдэц болон будгийн төв	1300 м ³	466	1,306	2023.08.08	2023.12.06	100%
1.11	Түр дэд бүтэц	80м шугам 2х30тн танк 2200м кабель	-	-	2023.07.06	2023.11.19	100%
2. Уурхайн барилга байгууламж							
2.1	Боловсруулах үйлдвэр	650,000 тн/жил	8,694	159,652	2023.08.23	2025.05.30	63.03%

2.2	Боловсруулах үйлдвэрийн оффис Уурхайн захиргааны барилга	29 хүн	184	1,025	2024.08.26	2025.04.28	35.45%
2.3	Цианидын агуулах Хүчлийн агуулах Хуурай бодисын агуулах "А"	70 хүн	1,080	3,564	2023.09.07	2025.02.02	76.84%
2.4	Хуурай бодисын агуулах "Б"	550 тн, 13 төрөл	143	328	2024.04.31	2025.02.02	37.97%
	Аюултай хог хаягдал түр хадгалах хэсэг Эмнэлэгийн тусламжийн барилга		31	83	2024.04.31	2025.02.02	
2.5	Агуулах	3400 м ³	621	3,859	2024.04.31	2025.02.02	86.02%
2.6	Хүнд, хөнгөн машин механизм, засварын газар	2 хүнд машин механизм, 1 тээврийн хэрэгсэл зэрэг засах	2,516	27,215	2023.07.22	2025.05.19	34.94%
	2.7	Халаалтын зуухны барилга	2.8 мВт, 1.4 мВ	851	4,680	2023.10.12	2025.01.25
2.8	Уурхайн шалган нэвтрүүлэх байр - 2	8 хүн	118	489	2024.05.02	2025.02.18	46.38%
2.9	Уурхайн шалган нэвтрүүлэх байр - 1	6 хүн	76	161	2024.10.10	2025.04.23	1.85%
2.10	Лабораторын барилга	135 дээж/өдөр	450	1,816	2024.05.02	2025.04.20	72.00%
	Усан хангамжийн систем	7820м шугам	-	-	2024.08.15	2025.04.20	57.74%
2.11	Гүний худгийн барилга	4ш	13.8	69	2024.08.15	2025.04.20	-
	500м3 хос усан сан	1000 м3	2x500	1,000	2024.08.15	2025.04.20	-
	50м3 хос усан сан	50 м3	24	98	2024.08.15	2025.04.20	-
	50м3 ил усан сан	50 м3	40	56	2024.08.15	2025.04.20	-
2.12	Гадна дулаан хангамж	2375м шугам	-	-	2024.05.06	2024.11.03	100.00 %
2.13	Урвуу осмосын төхөөрөмжөөс хаягдал ус зайлуулах шугам	900м шугам	-	-	2024.12.09	2024.02.19	10.00%
	Хаягдлын нэгдсэн сангийн ус цуглуулах сангаас Үйлдвэр үрүү ус шахах шугам	900м шугам	-	-	2024.12.09	2024.02.19	10.00%

2.15	Ахуйн хэрэглээний халуун, хүйтэн ус	3520м шугам	-	-	2024.05.06	2024.11.03	100.00 %
2.16	Гадна галын ус хангамж	945м шугам	-	-	2024.05.06	2024.11.03	100.00 %
2.17	Гадна бохир усны шугам	900м шугам	-	-	2024.05.22	2025.01.07	96.16%
2.18	Уурхайн ахуйн ус Цэвэрлэх байгууламж	40 м ³ /хоног	66	462	2024.01.02	2025.03.18	67.31%
	Цэвэрлэх байгууламж-Техникийн байр		16	48	2024.01.02	2025.03.18	
2.19	Цахилгааны дэд өртөө	4x2500kVA	218	874	2024.05.15	2025.02.19	72.71%
2.20	Давтамж хувиргуурын байгууламж	2.25 MVA, 2.8 MVA	75	234	2024.06.24	2025.02.17	71.42%
2.21	Гадна холбооны шугам сүлжээ	9340м кабель	-	-	2024.10.06	2025.02.18	79.89%
2.22	Уурхайн өндөр хүчдэлийн шугам	11kV, 4x800м, 240мм2	-	-	2024.10.06	2025.02.18	79.89%
2.23	Уурхайн гэрэлтүүлэг	43x150W	-	-	2024.03.20	2025.05.30	0.00%
2.24	Уурхайн газардуулгын систем	-	-	-	2024.03.20	2025.05.30	0.00%
2.25	Уурхайн гадна камерын систем	ш камер	-	-	2024.03.20	2025.05.30	1.17%
2.26	Уурхайн /хаягдлын нэгдсэн сан/	-	100,000	-	2024.09.02	2024.12.19	99.0%
2.27	Шатахуун түгээх байгууламж	-	-	-	2024.05.01	2025.08.01	-
2.28	Түр шороон нисэх зурвас	1000*30м	30,000	-	2024.12.22	2025.05.10	38.20%
2.29	Тэсрэх материалын агуулах	3	15000	892	2024.09.21	2025.01.15	56.0%
3. Уурхайн кемпийн барилга байгууламж							
3.1	Уурхайн ажилчдын кемп А- Block	370 хүн	522	1,598	2024.06.06	2025.04.20	30.57%
	Уурхайн ажилчдын кемп В- Block		679	7,634	2024.06.06	2025.03.15	20.28%
	Уурхайн ажилчдын кемп С- Block		679	7,554	2024.06.24	2025.04.19	43.22%
	Уурхайн ажилчдын кемп D- Block		713	5,338	2024.06.25	2025.03.27	47.15%
	Уурхайн ажилчдын кемп E- Block		773	5,244	2024.06.06	2025.04.20	29.73%
	Уурхайн ажилчдын кемп F- Block		727	3,179	2024.06.25	2025.04.06	31.09%

3.2	Кемп - Халаалтын зуухны барилга	0.7 мВт x 3 = 2.1мВт	648	3,960	2024.09.16	2025.03.30	35.48%
3.3	Кемп - Хувцас угаалга, авто зогсоолын барилга	8 машин	546	2,868	2024.08.12	2025.04.03	19.90%
3.4	Кемп - Шалган нэвтрүүлэх байр	8 хүн	75.8	160.5	2024.09.16	2025.03.30	35.48%
3.5	Кемп - Харуулын байр	1-2 хүн	15.2	34.9	2024.11.10	2025.03.11	35.48%
3.6	Кемп - Гадна дулаан	372м шугам	-	-	2024.08.22	2024.12.12	99.82%
3.7	Кемп - Гадна цэвэр ус	757м шугам	-	-	2024.10.01	2025.04.05	60.00%
3.8	Кемп - Гадна бохир ус	503м шугам	0	-	2024.08.21	2024.12.15	96.00%
3.9	Кемп - Бохир ус цэвэрлэх байгууламж	80 м ³ /хоног	95	665	2024.07.11	2025.04.05	24.44%
	Цэвэрлэх байгууламж-Техникийн байр		16	48	2024.07.11	2025.04.05	24.44%
3.10	Кемп - Гадна цахилгаан	1000kVA КТПН	-	-	2025.03.27	2025.04.16	0.00%
3.11	Кемп - Гадна гэрэлтүүлэг	34x150W	-	-	2025.03.20	2024.04.08	0.00%
3.12	Кемп - Гадна холбоо дохиолол	1125м кабель	-	-	-	-	0.00%
3.13	Кемп - Гадна камерын систем	ш камер	-	-	-	-	0.00%
3.14	Уурхайн кемп-Уурхайн хүртэлх шороон зам	9063	81567	-	2024.05.24	2025.04.25	84.59%
4.1	Түр шороон нисэх зурвас	1000*30	30,000	-	2024.12.22	2025.12.22	38.2%

Бид хайгуулын үе шатнаас эхлэн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн холбогдох дүрэм, журмуудыг баримтлан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилгоо биелүүлж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн орон нутгийн хамтын ажиллагааг хангаж ажилласаар ирсэн.

4.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг, орчны хяналт

шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон тусгасан. БОМТ-г хэрэгжүүлэхэд 2025 онд зарцуулах зардлыг 300,000,000.00 (Гурван зуун сая) төгрөг, “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд 126,000,000.00 (Нэг зуун хорин зургаан сая) төгрөг байхаар тооцлоо. Төслийн БОМТ хэрэгжүүлэхэд зарцуулах зардлуудын хураангуйг доор харуулав.

Хүснэгт 9. БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2025 он

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, сая.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө	142,88 сая
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,24 сая
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	84,10 сая
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10,00 сая
6.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	53,21 сая
8.	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	8,56 сая
9.	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
10.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах	Үйл ажиллагааны зардал
Нийт		300,00 сая
Тэрбум мод хөтөлбөр		126,00 сая

4.3.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг Хүснэгт 9 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг бүрэн эхээр нь харуулав. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү **төлөвлөгөөг** бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Барилга байгууламжууд барих хөрс хуулалт хийх, уурхайн доторх зам ба талбайд газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх	Барилга, уурхайн олборлолтын үйл ажиллагааны хүрээнд	Хүссэн, олгосон талбайн тоо, хэмжээ, га	-	76.0 га	Үйл ажиллагааны зардал	Барилгажилт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед 2025 он	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, "Эрдэнэ" - ийн бодлого журмын гарын авлага
	Буцаан дүүргэлтийн материал олборлож байгаа карьеруудын мэдээллийг бүртгэлжүүлэх Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх	Барилга, уурхайн олборлолтын үйл ажиллагааны хүрээнд	Хүссэн, олгосон талбайн тоо, хэмжээ, га			Үйл ажиллагааны зардал	Барилгажилт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед 2025 он	
	Үйл ажиллагааны багуудад газар шорооны ажил эхлэх зөвшөөрөл олгохтой холбоотой сургалт зохион байгуулах	Барилга, уурхайн олборлолтын үйл ажиллагааны хүрээнд	Сургалт авсан ажилчдын тоо	-	2	Үйл ажиллагааны зардал	Барилгажилт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед 2025 он	
	Барилга байгууламж, уурхайн үйл ажиллагааны үед олон салаа зам гаргахгүй, шаардлагатай тохиодолд дотоод замын маршрутыг	Барилга, олборлолтын үйл ажиллагааны хүрээнд	Удаа	-	2	Үйл ажиллагааны зардал	Барилгажилт ын үед 2025 он	

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага	
	шинэчлэн батлаж, мөрдүүлэх								
	Шаардлагатай цэгүүдэд замын тэмдэг байрлуулах /ан амьтан гарч ирж болзошгүй/	Төслийн талбайд	Тоо ширхэг	250.0	10	2,500.0	2025 он	Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйл, 17.3 дахь заалт, 23 дугаар зүйл 23.1 дэх заалт, MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм	
Хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг стандартын дагуу зөв хадгалж, ашиглах	Шимт болон шимэрхэг хөрсний үржил шим алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (5 метрээс өндөргүй овоолох)	Ил уурхайн талбай	Хуулсан шимт болон шимэрхэг хөрсний хэмжээ, м ³	-		Шимт болон шимэрхэг хөрсний хуулалт хийгдэх бүрт	Үйл ажиллагааны зардал	Барилгажилт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед 2025 он	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, "Эрдэнэ" - ийн бодлого журмын гарын авлага
ХОЁР. ХӨРСӨН БҮРХЭВЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Тээврийн хэрэгслүүдийн явах эд ангиуд гэмтэх, хүний болгоомжгүй	Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтад авах арга хэмжээний дотоод журмыг хэрэгжүүлэх	Барилгын үйл ажиллагааны хүрээнд	Асгаралт бүртгэгдсэн тоо	-	-		Үйл ажиллагааны зардал	2025 он	Сонгож авсан шингээгч материалгыг хэрэглэх зааварчилгаа

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
үйлдлээс ШТМ гоожиж, асгарсан тохиолдолд тухайн орчны хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй.								
Барилгын ажлын үед машин, механизмуудын засварын газраас гарсан ашигласан тос, тослох материалыг түр хадгалах саванд цуглуулах, түр хадгалах явцад дамжуулах шугам хоолойн гэмтэл, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдуулж болзошгүй	Авто машины засварын газраас гарах ашигласан тос, тосолгооны материалыг зориулалтын саванд хуульд заасан хугацаанд түр хадгалах	Засварын цэг	Хадгалсан хог хаягдлын хэмжээ, ш, м ³	-	-	-	2025 он	“Шатахуун түгээх станц, Галын аюулгүйн норм” /БНБД 21-07-14/
Ачаа тээврийн ажиллагаанаас олон салаа зам гарган хөрсний элэгдэл үүсгэж болзошгүй	Шаардлагатай цэгүүдэд замыг сайжруулах ажлыг зохион байгуулах	Ачаа тээврийн зам дагуу	Шаардлагатай цэгүүд	-	-	Үйл ажиллагааны зардал	Барилгын ачаа тээврийн үед	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3);

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
	Шаардлагатай хэсгүүдэд усалгааг байгуулах замын зохион	ТТАМ олборлох талбайн зам	Шаардлагатай хэсгүүд	200.0	100	20,000.0		
Химийн бодисын буруу хадгалалт, байгалийн гэнэтийн аюултай үзэгдлээс химийн бодис асгарч газрын гадарга хэвлийг бохирдуулж болзошгүй.	Химийн бодисуудыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хадгалах	Химийн бодисын агуулах	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Химийн бодисын агуулах ашиглалтад орох үед	Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө, БОАЖСайд, ЭМСайд, ОБЕГ-ын даргын 2009 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 28/40/29 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт Химийн хор болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, устгах журам.
ГУРАВ. УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс нүүрхүчлийн хий ялгарч мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлнэ.	Түлшний хэрэглээ бүртгэх, ялгаруулж байгаа хүлэмжийн хийг тооцох	Нүүрс, түлшний хэрэглээ	Удаа	-	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал	2025 он	*MNS ISO 14064-1 - 2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж) *Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага бичиг, сайн тогтоол
								(УИХ-ын 2011.01.06 тогтоол)
ДӨРӨВ. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Эвдрэл, элэгдэлд өртсөн, хөрсөн бүрхэвч талхлагдсан хэсгүүдээс тоос шороо агаарт дэгдэх	Замын усалгааг хуваарийн дагуу хийх	Шороон зам, тээврийн хэрэгслүүд	Усалгаа хийсэн өдрийн тоо	375,9	200	75,184.0	2025 он	Усны тухай хууль (2012) 32.8 дугаар зүйл
	Тоос дарагч бодисыг устай хольж туршиж үзэх	Шороон замын туршилтын хэсэг	Усалгаа хийсэн өдрийн тоо	10,000.0	1	10,000.0	2025 он	
	Тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцох хурдны дээд хязгаарыг 40 км/цагаас хэтрүүлэхгүй байх	Тээврийн хэрэгсэл, шороон замууд	Өдөрт хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн тоо	-	-	-	2025 он	Агаарын тухай хууль MNS 4585 :2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
ТАВ. ГАДАРГЫН УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Барилга байгууламж, уурхайн доторх замыг сайрууд дээр байгуулснаар сайрын гольдрол өөрчлөгдөх	Гадаргын уснаас хамгаалах систем байгуулах ажлын суваг хүрээнд байгуулах	Төслийн талбай орчимд	-	-	1	Хөрөнгө оруулалтын зардал	2025 он	Мэргэжлийн компанийн гүйцэтгэсэн зураг төслийн дагуу ажлыг гүйцэтгэнэ.
Хаягдлын нэгдсэн сан баригдсанаар сайрын голдрил өөрчлөгдөнө	ХНС-ийн хойд хэсгээр ус зайлуулах далан, сувгийг байгуулах	Хаягдлын нэгдсэн сан	-	-	1	Хөрөнгө оруулалтын зардал	2025 он	Баянхөндий алтны уурхайн зам талбайн борооны ус шүүрүүлэх байгууламжийн зураг төсөл, 2024.
ЗУРГАА. ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
Газрын доорх усны нөөц багасгах	Ус авах худаг нэмэгдсэн тохиолдолд тухайн ус хангамжийн эх үүсвэрийг тоолууржуулах	Ус хангамжийн худгууд	Тоо ширхэг	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	Усны тухай хууль 30.1.4; Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны "Журам батлах тухай" 156 тоот тушаал
	Мониторингийн цооногт логгер суурилуулах	Мониторингийн цооног	Тоо ширхэг	-	1	Үйл ажиллагааны зардал	2025 он	Усны тухай хууль
	Ус хангамжийн худгуудын тоолуурын заалтыг тогтмол бүртгэх, сумын байцаагч эсвэл байгаль хамгаалагчаар баталгаажуулах ажлыг зохион байгуулах	Ус хангамжийн худгууд	Удаа	-	4	Үйл ажиллагааны зардал	2025 он	Усны тухай хууль
	Усыг хэмнэлттэй, зохистой ашиглах сургалт, мэдээллийг ажилтнуудад хийх	Төслийн ажилтнууд	Сургалтын тоо	-	2	Үйл ажиллагааны зардал	2025 он	Усны тухай хууль
	Ил уурхайд ус шүүрсэн тохиолдолд усыг зам усалгаанд ашиглах	Баянхөндий ил уурхай	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	Усны тухай хууль
ШТМ, аюултай болон хортой бодис асгарч, хаягдсан тохиолдолд газрын	Усны сан бүхий газрын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах	Ус хангамжийн худгууд	Тоо ширхэг	500.0	4 худаг	2,000.0	2025 он	Усны тухай хууль

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага, зүйн бичиг, сайн	
доорх усыг бохирдуулах									
Боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас химийн бодис агуулсан ус алдагдаж газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Химийн бодис гоожиж, асгарч болох хэсгүүдэд хяналтын камер, мэдрэгчүүдийг суурилуулах	Боловсруулах үйлдвэр Химийн бодисын агуулах	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он		
	Химийн бодисыг тээвэрлэх үеийн савны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгах	Боловсруулах үйлдвэр Химийн бодисын агуулах	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он		
ДОЛОО. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Уурхайн түр байгууламжууд, агуулах барих, зам засах үед ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдах	Уурхайн барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтаар үүссэн түр, зам талбайг хааж, байгалийн аясаар ургамал ургах нөхцлийг бүрдүүлэх	Барилгажилтын дараа буюу үйл ажиллагааны туршид нөхөн сэргээх боломжтой газрууд	га	-		Барилгажилтын үед талхлагдсан газрууд	Үйл ажиллагааны зардал	2025 он	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3);
Түр байгууламжууд, агуулах барих, зам засахад ховор ургамлууд нөлөөлөлд өртөх	Газар хөндөлтийн өмнө тухайн талбай дахь нэн ховор, ховор ургамлыг бүртгэх	Потанины хотир, Регелийн будраа	Талбайн хэмжээ, м ²	-		Газар шорооны ажил эхлэх бүрд	Үйл ажиллагааны зардал	2025 он	Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл, 2012, 2019
	Газар шорооны ажил эхлүүлэхийн өмнө талбайн үзлэгээр нэн ховор, ховор ургамал бүртгэгдсэн тохиолдолд нөлөөлөлд	Потанины хотир, Регелийн будраа	Бодгалийн тоо	-		Шилжүүлэн тариалсан нэн ховор, ховор ургамлын	Үйл ажиллагааны зардал	2025 он	

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
	өртөх ургамлыг шилжүүлэн тарих				бодгалийн тоо			
	Модны усалгааг дэмжих хувинг туршлтаар хэрэглэх	Ургамал үржүүлгийн талбай	ширхэг	1,000	5,250.0	52,500.0	2025 он	
Хүн амын суурьшил нэмэгдсэнээр заг, бутлаг ургамлыг түүж болзошгүй	Хууль бусаар ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тэвэрлэх, ашиглахыг хориглон, уурхайн шалган нэвтрүүлэх хэсэг, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийх	Тээврийн хэрэгсэл	Удаа	-	Сард 1 удаа	Үйл ажиллагааны зардал	2025 он	Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES); Ойн тухай хууль 29.1.11
Байгаль орчны чиглэлээр туршилт, судалгаа явуулах	БНХАУ-д судалсан өвсөн дөрвөлжийг турших	Төслийн талбайн хүрээнд	Удаа	-	-	13,200.00	2025 он	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3);
Байгаль орчны мэдлэг дутуугаас ургамал тасдаж болзошгүй	Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Биологийн олон янз байдлын мэдлэг олгох” сургалтад хамруулах	Уурхайн талбай, түүний орчимд тархах биологийн төрөл зүйл	Сургалт авсан ажилчдын тоо	-	Уурхайн талбайд ажиллахаар анх удаа ирж буй ажиллагсдад ажил эхлүүлэхээс өмнө сургалтыг тогтмол хийх	Үйл ажиллагааны зардал	2025 он	Уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны сургалт, зааварчилгаа, дотоод журам

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага бичиг, сайн
НАЙМ. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Хүн амын суурьшил, тээврийн хэрэгслийн дуу чимээ, гэрэл зэргээс амьтад байршиж буй газар нутгаасаа үргэж дайжихаас гадна, тээврийн хэрэгсэлд дайруулж болзошгүй	Зөвхөн батлагдсан замын сүлжээг ашиглах ба тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоож, мөрдүүлэх	Уурхайн засвар, үйлчилгээний техник хэрэгслүүд	Замын маршрут	-	-	-	Өдөр бүр	Уурхайн дотоод журам болон аюулгүй ажиллагаа, байгаль орчны зааварчилгаа
Байгаль орчны мэдлэг дутуугаас амьтныг үргээж, элдэж, алж болзошгүй	ОХШХ-ийн дагуу амьтны хяналт мониторингийг хэрэгжүүлж, бүртгэл хөтлөх	Уурхайн талбай, түүний орчимд тархах	Удаа		Улиралд 1 удаа	-	2025 он	Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025
Байгаль орчны мэдлэг дутуугаас амьтныг үргээж, элдэж, алж болзошгүй	Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Биологийн олон янз байдлын мэдлэг олгох” сургалтад хамруулах	Уурхайн талбай, түүний орчимд тархах биологийн төрөл зүйл	Сургалт авсан ажилчдын тоо	-	Уурхайн талбайд ажиллахаар анх удаа ирж буй ажиллагсад болон зочдод ажил эхлүүлэхээс өмнө сургалтыг тогтмол хийх	Үйл ажиллагааны зардал	2025 онд	Уурхайн аюулгүй ажиллагаа, байгаль орчны сургалт, зааварчилгаа, дотоод журам
Хүн амын суурьшил нэмэгдсэнээр хууль бус ан хийгдэж болзошгүй	Хууль бусаар амьтан агнах, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох, уурхайн шалган нэвтрүүлэх хэсэг, тээврийн	Тээврийн хэрэгсэл	Удаа	-	Сард 1 удаа	Үйл ажиллагааны зардал	2025 он	Амьтны тухай хууль, 2012 6.1.7 үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх; Зэрлэг

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, зүйн бичиг, сайн туршлага
	хэрэгсэлд хяналт шалгалтыг хийх							амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)
Шувууд эрсдэж болзошгүй	Шувууд (элдэв идэшт) цуглах таатай орчин бүрдүүлэхээс зайлсхийж хоол хүнсний үлдэгдлийг ил задгай хаяхгүй бай, холбогдох хяналт тавих	Элдэв идэшт шувууд (хон хэрээ, алагтуу хэрээ, хөхвөр тагтаа, алаг шаазгай, сохор элээ)	Удаа	-	Сард 1 удаа	Үйл ажиллагааны зардал	2025 он	Уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
ЕС. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар тархан амьдрах амьтад үргэж дайжих, хууль бус ан хийх	Мазаалай баавгайд байршил тогтоогч хүзүүвч суурьлуулах	Говийн их ДЦГ-ын А хэсэг	ширхэг	20,000.0	1	20,000.0	2025	БОАЖЯ/хуучнаар/-тай байгуулсан хамтран ажиллах санамж бичиг
АРАВ. ДУУ ШУУГИАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугианы нөлөөлөх үүсэх ба ажилчдын эрүүл	Хэт өндөр дуу шуугиантай (80dBA-аас дээш) орчинд ажилладаг ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл тогтмол ашиглуулах	Төслийн ажилчид	-	-	Барилгын ажлын үед	Үйл ажиллагааны зардал	Ажиллах хугацаанд	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага бичиг, сайн
мэндэд нөлөөлж болзошгүй								
Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугиан үүсэж, ойролцоо орших нутгийн 1 малчин айлын тав тухад сөргөөр нөлөөлж болзошгүй.	Энэ айл өвөлжөөндөө өвөлжиж байгаа үед сард 1 удаа дуу шуугианы хэмжилт хийх, үр дүнгээс хамааран давтамжийг өөрчлөх	1 малчин айл П.Нямсүрэн (3.2 км)	удаа	-	2	ОХШТ-нд туссан	2025 он	Санал гомдол шийдвэрлэх механизм
АРВАН НЭГ. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох талбайн ойр нутаглаж буй малчин өрхүүдийн мал үүсгэсэн карьерт унан эрсдэж болзошгүй	Нутгийн иргэдэд уурхайн үйл ажиллагааны мэдээлэл өгч ажиллах	Баянхөндий төслийн тусгай зөвшөөрөлтэй талбай	Удаа	-	2	Үйл ажиллагааны зардал	2025 он	Санал гомдол шийдвэрлэх механизм
Нутгийн иргэд Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлгүй байх, болон малчин иргэдийн хооронд маргаан үүсч болзошгүй	Төслийн мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэх	Баянхөндий төслийн үндсэн болон туслан гүйцэтгэгч компанийн нийт ажилчид	Мэдээлэл авсан иргэдийн тоо	-	30	Үйл ажиллагааны зардал	2025 он	Санал гомдол шийдвэрлэх механизм
	Шинээр ажилд орж байгаа ажилчдад нутгийн иргэдтэй хүндэтгэлтэй харьцах	Баянхөндий төслийн үндсэн болон туслан гүйцэтгэгч	Мэдээлэл авсан иргэдийн тоо	-	50	Үйл ажиллагааны зардал	2025 он	Санал гомдол шийдвэрлэх механизм

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
	зааварчилгааг ерөнхий зааварчилгаагаар дамжуулан олгох	компанийн нийт ажилчид						
Шинэжинст сумын иргэдээс ажилд орох хүсэлтэй боловч боловсрол, ажлын туршлага хангалтгүйгээс орж чадахгүй байж болзошгүй	Баянхөндий төсөлд ажиллах хүсэлтэй орон нутгийн иргэдийг бүртгэх, ажлын байрны шаардлага хангасан иргэдийг төслийн хүчин чадалд тохируулан ажлын байраар хангах	Баянхөндий төсөлд ажилд орох хүсэлтэй орон нутгийн иргэд болон төсөл хэрэгжүүлэгч	Ажилд орсон иргэдийн тоо	-	20	Үйл ажиллагааны зардал	2025 он	Хүний нөөцийн бодлого
	Шинээр ажлын байр зарлагдсан тухай бүрт зарыг www.zangia.mn сайтад байршуулах	Баянхөндий төслийн үндсэн болон гэрээт ажилчид	Зарын тоо		1	Үйл ажиллагааны зардал	2025 он	Хүний нөөцийн бодлого
Орон нутагт уул уурхайтай холбоотой хүн амын хөдөлгөөн нэмэгдэхийн зэрэгцээгээр архидалт, гэмт хэргийн гаралт өсч болзошгүй	Төслийн талбайд архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох зааварчилгааг “Талбайн ерөнхий зааварчилгаа”-аар дамжуулан олгох	Төсөл хэрэгжүүлэгч, туслан гүйцэтгэгч компаниуд	Согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчлийн тоо	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм

4.4.Нөхөн сэргээлтний төлөвлөгөө

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн талбайд нөхөн сэргээх арга хэмжээ авч, газрын эвдрэлийг хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлздэг. “Баянхөндий” төслийн барилгын ажил 2025 онд үргэлжлэх ба барилгажилтын явцад эвдрэх газрын хэмжээг хамгийн бага байлгах үүднээс төслийн талбайд “Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл”-ийн журмыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөт онд нөхөн сэргээлт хийхгүй хэдий ч ил уурхайн хөрс хуулалтын ажил эхэлсэн тохиолдолд ирээдүйн нөхөн сэргээлтэнд хэрэглэх шимт болон шимэрхэг хөрсийг хөрсний зүсэлтэд үндэслэн 30 хүртэлх см зузаантай хуулж, стандартын дагуу хадгална. Түүнчлэн, нөхөн сэргээлтний ажилд бэлдэх үүднээс байгалийн ургамал үржүүлгийн газарт өнгөрсөн онд түүж, хадгалсан нутгийн ургамлын үрээр тарилт хийх, өнгөрсөн онд тариалсан тарьц суулгацыг үргэлжлүүлэн арчлах, шилжүүлэн тариалалтад бэлдэх, тодорхой хэмжээний нутгийн ургамлын үр бэлдэх, нөлөөлөлд өртөх ховор, нэн ховор ургамлыг шилжүүлэн тариална. Мөн геологийн хайгуулын цооног өрөмдөх, суваг нэвтрэлтийн ажлын үед эвдэгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж, анхны төрхөнд ойртуулна.

Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага
Шимт хөрсийг овоолгод тогтвортой байршуулж, нөхөн сэргээлтэд ашиглахад бэлтгэх	Төслийн барилгажилтын үед 76 га талбайгаас зохистой хэмжээний зузаантай хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг, талбай руу тээвэрлэх, овоолго үүсгэх	м ³	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
	Шимт хөрсний овоолгын хөрсний үржил, шимт чанарыг алдагдуулахгүй байх усалгаа хийх	удаа	2	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	
	Шимт хөрсний овоолгыг холбогдох стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих	Удаа	-	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	
Ургамал үржүүлгийн талбайн хөрс сайжруулах бэхжүүлэх	Нутгийн ургамлын үр түүх	кг	26	24.0	640.0	2025 оны III, IV улиралд	Байгалийн ургамлын тухай хууль 13.3 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025
	Нутгийн ургамлын үрээр тариалалт хийх	ш	10,000	5.0	50,000	2025 он	
	Салхины нөмөрлөгчийн зориулалтаар ургамал үржүүлгийн талбайн өргөтгөлд мод тарих	ш	4,500	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	
	Төслийн эзэмшлийн талбайд суулгац шилжүүлэн тарих	ш	3,000	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага
Газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах	Цооног өрөмдсөн, суваг малтсан, газар шорооны түр ажил хийгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлтийн стандартыг баримтлан анхны төрхөд ойртуулах	ш	Хаасан газар шорооны ажлын зөвшөөрлийн тоогоор	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008”

4.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

4.5.1. Дүйцүүлэн хамгааллын талаар баримтлах бодлого

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн бүс нутгийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэх зорилготой ажиллаж байгаа билээ. Энэхүү зорилгодоо уурхайн хаалтын үед хүрсэн байхаар зорьж байгаа хэдий ч төсөл хэрэгжих хугацаанд аль болох эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно. Үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа юун түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ.

Бид нийгмийн хариуцлагын хүрээнд “Үйл ажиллагааны сайн дурын кодекс”-г 2016 онд нэгдсэн орсон ба МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг дэмжин нэг сая мод тарихаар төлөвлөж байна.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалалт зорилт	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ, ширхэг	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага
Бүс нутгийн биологийн төрөл зүйлийн судалгаа	Баянхонгор аймгийн говийн бүсийн сумдын биологийн төрөл зүйлийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх	1	50,000.0	50,000.0	2025-2026	Баянхонгор аймгийн БОГ-ын санал
Байгалийн амьдрах орчныг нөхөн сэргээх	Тарьц, суулгац бэлдэх	2,000	5,0	1,000.0	2025 он	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод тарих" үндэсний хөдөлгөөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 9.6 дугаар Заалт
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	Нутгийн иргэдтэй хамтран мод тарих	4,500	5,0	22,500.0	2025 он	
	Шинэжинст сумд хөв байгуулах	1	20,000.0	20,000.0	2025 оны III улирал	
	Цагаан сайрын худгийг засварлах	1	5,000.0	5,000.0	2025 оны II улирал	
	Бэлчээрийн ус хангамжийг сайжруулах (худаг засварлах)	2	-	Үйл ажиллагааны зардал	2025 он	
	Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах	1	9,100.0	9,100.0	2025 оны I улиралд	

4.5.2. Нөлөөлөлд өртөх болон дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ


“Баянхөндий төслийн ил уурхайн олборлолт, Боловсруулахүйлдвэр, дэд бүтцийн бүтцийн байгууламжууд нь талбай болон зурвас хэлбэрийн нөлөөлөл үзүүлэх ба нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ “Нөлөөлөл бууруулах программ” (Mongolian Mitigation Design Tool)-д тооцсоноор 1,041 га (337.5 га их, 107.5 га дунд, 595.9 га бага эрчимтэй), дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайн хэмжээг мөн “Нөлөөлөл буурах программ”-д тооцсон ба 5,721 га буюу нөлөөлөлд өртөх талбайгаас 5 дахин их байна.” гэж БОННУ-д тусгагдсан.

4.5.3. Дүйцүүлэн хамгаалах газрын санал болгож байгаа байршлууд

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжит газрын байршлаар ГИДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд орших Эдрэнгийн нуруу, Номингийн говь болон Баянбулагийн тал гэсэн 3 байршлыг санал болгосон. Өмнийн говийн Экологийн бүс нутгийн үнэлгээгээр Эдрэнгийн нуруу, Номингийн говь, хамгаалах шаардлагатай газруудад Баянбулагийн тал Шинээр хамгаалах шаардлагатай газрын ангилалд хамаарагдана.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8,000 га талбайг нөхөн сэргээх төлөвлөгөөний дагуу компани нөхөн сэргээхээр төлөвлөсөн 6.3 га талбайгаас 2.5 дахин их буюу 15.6 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. Их Богдын БЦГазрын хамгаалалтын захиргаатай хамтран улсын тусгай хамгаалалттай газар нутаг болох Баянговь, Баянлиг сумдын нутагт 14 га, Шинэжинст сумын Түймэрт хэмээх газарт 1.6 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. Өлзийт сумын Ар Өнц хэмээх газарт 10 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж аймгийн комисст хүлээлгэн өгсөн.

Судлаач Н.Батсайхантай хамтран 2022 онд эхэлсэн “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа” тандан судалгааны тайлан, Эрдэнэ Монгол ХХК-ийн Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Техник эдийн засгийн үндэслэл”-д тулгуурлан “Нөлөөлөлд өртсөнтэй экологийн хувьд аль болох “ижил” төрлийн бүтэц, хэв шинж, үнэ цэнэ, үйл явц бүхий амьдрах орчныг сонгон авч дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ” зарчмын дагуу төслийн нөлөөлөлд өртөх амьдрах орчинтой аль болох ижил амьдрах орчныг сонгон, дүйцүүлэн хамгааллын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.



Зураг 26. Нөхөн сэргээлт хийсэн газрын байршил, 2022 он

4.6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

“Эрдэнэ Монгол” ХХК нь 2025 онд барилга, байгууламжийг барих ажлыг үргэлжлүүлэх, төслийн зам талбайг засах ажлуудыг хэрэгжүүлнэ. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг барилгын ажлын үе шаттай уялдуулан 2025 оны II-III улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан.

Хүснэгт 13. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Талбайн хэмжээ, м ²	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага
Кемпийн тохижилт, өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Тариалсан суулгацыг арчилж ургуулах, нэг наст цэцэг тарих	60	10.0	600.0	2025 оны II-III улирал	Газрын тухай хууль 56.6

4.7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Д.Баасандаш (1.9 км), Б.Ганбат (2.8 км), П.Нямсүрэн (3.2 км) нарын өвөлжөөний газар хамгийн ойр байршдаг. Дээрх малчин өрх нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд жил бүр ирж нутагладаггүй.

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас үзүүлж байгаа нөлөөлөл тус өрхийн гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулах, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй нь хяналт шинжилгээний хөтөлбөр болон бусад холбогдох баримтуудаар тогтоогдвол нүүлгэн шилжүүлэх ажлыг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй малчин өрх, Шинэжинст сумын удирдлагатай хамтран зохион байгуулна.

Хүснэгт 14. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, мян. төгрөг	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Барилга барих үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, тоосжилтоос ойролцоо нутаглаж буй малчин өрхийн гишүүдэд тавгүй байдал үүсгэж болзошгүй	Уурхайн үйл ажиллагаанаас үүсч буй дуу чимээ, тоосжилт нь ойролцоох өвөлжөөнүүдийн орчимд агаарын чанарын стандарт хэмжээнд байгаа эсэхийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тодорхойлж, шаардлагатай тохиолдолд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх.	Төслийн талбайн ойролцоох 3 өвөлжөөний орчимд	-	-	2025 он	Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2021 он

4.8.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёлын өв олоход магадлалтай. Хэрэв барилгын болон үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд газар шорооны ажлын үйл ажиллагааг түр зогсоож дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Барилгын ажлын явцад өмнө нь судалж тогтоож чадаагүй палеонтологи болон археологийн үнэт олдвор илэрвэл илэрсэн даруйд ажлаа зогсоож, олдворын талаар сум/аймгийн Засаг даргад мэдэгдэнэ.
- Бүртгэсэн соёлын өв, түүхийн үнэт олдворын эргэн тойронд эрх бүхий байгууллагын зөвлөмжийн дагуу хамгаалалтын бүс байгуулах ба хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий байгууллага бүртгэгдсэн тэдгээр зүйлсийг нүүлгэн шилжүүлнэ.
- Чухал ач холбогдол бүхий түүх соёлын олдвор, үнэт зүйлс олдсон тохиолдолд зөөвөрлөнө. Ингэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралт “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ыг баримтална.

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хүснэгт 15. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримталх стандарт, аргачлал
Газар шорооны ажлын үед том оврын техник хэрэгслээр хөрс хуулах, суваг шуудуу ухах зэрэг ажил хийгдэх явцад өмнөх судалгааны явцад илрээгүй, хөрсөнд хадгалагдан үлдсэн байж болзошгүй археологи, палеонтологийн олдвор санамсаргүй байдлаар тохиолдож, нөлөөлөлд өртөх	Археологи, палентлогийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх зааварчилгааг туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд өгөх	Төслийн ажилчдад	-	-	Уурхайн талбайд ажиллахаар анх удаа ирж буй ажиллагсад болон зочлод ажил эхлүүлэхээс өмнө сургалтыг тогтмол хийх	“Эрдэнэ Монгол” ХХК-ийн бодлогожурмын гарын авлага
	Олдвор илэрсэн тохиолдолд орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, туслалцаа үзүүлэн хамтарч ажиллах	Төслийн талбайд	10,000.0	10,000.0	2025 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 27.8

4.9.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Эрдэнэ монгол” ххк нь үндсэн болон гэрээт компаниудын ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг монгол улсад мөрдөгддөг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль, олон улсын стандарт, конвенц, ил уурайн аюулгүй байдлын дүрэмд зааснаар хангаж ажилладаг.

Бид зөвхөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-шаардлага, хэрэглэх заавар ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлээд зогсохгүй чанарын менежментийн тогтолцоо-шаардлага ISO 9001:2015, байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар ISO 14001:2015 стандартыг цогцоор нь төслийн бүхий л үе шатад хэрэгжүүлж, монгол улсын уул уурхайн компаниудын дунд үлгэр жишээ менежментийн тогтолцоог системтэйгээр бий болгож ажиллах зорилготой.

Хүснэгт 16. Осол эрдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Гал түймэр гарах	Галын идэвхитний бүлэг байгуулж, бүлгийн ажилтнуудыг сургалт дадлагад хамруулах Гал унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж дагаж мөрдөж ажиллах	Төслийн талбай дахь барилга, байгууламжууд	-	2	Үйл ажиллагааны зардал	2025 он	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4.
	Бүх ажлын талбайд галын дохиолол, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавих	Төслийн талбай дахь барилга, байгууламжууд	-	Бүх ажлын байранд	Үйл ажиллагааны зардал	Барилгыг ашиглалтад оруулахад байршуулсан байх бөгөөд хэвийн ажиллагааг тогтмол шалгах	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3 барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах
	Галын дохиолол, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах	Түр барилга, байгууламжууд, уурхайн агуулах, ШТС	-	Бүх гэр, ажлын байранд	Үйл ажиллагааны зардал	Барилгыг ашиглалтад оруулахад байршуулсан байх бөгөөд хэвийн ажиллагааг тогтмол шалгах	
	Гал унтраагуурыг зохих газруудад байрлуулах,	Түр барилга, байгууламжууд, уурхайн агуулах, ШТС, тээврийн хэрэгсэл, ашиглалтанд орох барилга байгууламж	-	Бүх гэр, ажлын байранд	Үйл ажиллагааны зардал	2025 он	

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байглийн гамшигт үзэгдэл	Төслийн хэмжээнд гамшигаас хамгаалах төлөвлөгөө батлуулж бэлэн байдлыг хангах	Төслийн талбай	-	1	Үйл ажиллагааны зардал	2025	Гамшигаас хамгаалах тухай хууль
Химийн хорт бодисын болон гэсрэх бодисын хадгалалт, ашиглалтаас БО-нд сөрөг нөлөө үзүүлэх	Холбогдох журмын дагуу хадгалаж, ашиглах	Химийн бодисын агуулах, Гэсрэх бодисын агуулах	-	Тухай бүр	Үйл ажиллагааны зардал	2025	Химийн бодисын тухай хууль
Хүний эрүүл мэнд муудах	Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Анхан шатны тусламж үзүүлэх сургалт”-нд хамруулах	Үндсэн болон гэрээт ажилчид	-	Сургалт авсан ажилчдын тоо	Үйл ажиллагааны зардал	Уурхайн талбайд ажиллахаар анх удаа ирж буй ажиллагсад ажил эхлүүлэхээс өмнө	-
	Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг урьдчилан сэргийлэх эмнэлгийн үзлэгт хамруулах	Үндсэн болон гэрээт ажилчид	-	Үзлэгт хамрагдсан ажилчдын тоо	Үйл ажиллагааны зардал	2025 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг
	Хүний эрүүл мэнд муудахад анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бол ойр газар руу нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах	Төслийн хэмжээнд	-	Шаардлагатай тохиолдолд	Үйл ажиллагааны зардал	2025 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Химийн бодисын хордолгын үед яаралтай тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах	Төслийн хэмжээнд	-	Шаардлагатай тохиолдолд	Үйл ажиллагааны зардал	2025 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг
Тээврийн хэрэгслийн осол гарах	“Төслийн талбайд жолоодох эрх олгох сургалт зохион байгуулах, шалгалтанд тэнцсэн ажилтанд жолоодох эрх олгох	Төслийн талбайд жолоодох эрхтэй жолооч	-	Шаардлагатай тохиолдолд	-	2025 он	“Эрдэнэ Монгол” ХХК-ийн бодлого журмын гарын авлага

4.10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Эрдэнэ Монгол ХХК нь холбогдох хууль дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг удирдлага зохицуулатын журмыг боловсруулан мөрдөн ажилладаг. Хог хаягдлыг дараах байдлаар ангилан цуглуулж, боломжит хог хаягдлыг зориулалтын газар устгах, уурхайн талбайгаас зохих газарт шилжүүлэх, дахин боловсруулалтанд илгээх зэрэг арга хэмжээг авч ажиллана.

Хог хаягдлын хуулийн дагуу АХХ үүсгэгчийн дугаар (Y-001587), Энгийн хог хаягдал үүсгэгчийн дугаар (Y-000088) дугаар авсан бөгөөд холбогдох журмын дагуу тайланг хүргүүлж ажиллаж байна.

Хүснэгт 17. Хог хаягдлын ангилал, тэдгээрийг устгах аргууд

№	Хог хаягдлын төрөл	Устгах арга	Хаана
1.	Энгийн хог хаягдал	Гэрээний дагуу	Зөвшөөрлийн дагуу ландфиллын талбай байгуулан булшлах
2.	Үйлдвэрлэлийн болон ахуйн бохир ус	Байгальд нийлүүлэх хаягдал усны стандартад нийцүүлэн цэвэрлэх	Уурхайн хаягдлын нэгдсэн санд байршуулах
3.	Хуванцар	Дахин ашиглаглах эсвэл дахин боловсруултанд шилжүүлэх	Хоёрдогч түүхий эд авах төвд нийлүүлэх
4.	Метал	Дахин ашиглах эсвэл дахин боловсруултанд шилжүүлэх	Хоёрдогч түүхий эд авах төвд нийлүүлэх
5.	Хаягдал дугуй	Дахин ашиглаглах эсвэл дахин боловсруултанд шилжүүлэх	Иргэдийн хүсэлтийн дагуу олгох, хоёрдогч түүхий эд авах төвд нийлүүлэх
6.	Химийн бодисын сав, баглаа боодол	Дахин боловсруулалтад шилжүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан шилжүүлэх
7.	Хаягдал тос	Дахин боловсруулалтад шилжүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан шилжүүлэх
